




МОНЭС

Өөрчлөлт миний гарт

ЖЕҢДЭРТ СУУРИЛСАН
ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ, ХАҢДЛАГА,
ЧАДВАР ОЛГОХ ХИЧЭЭЛ

- БАГШ НАРТ
- ЗОРИУЛСАН
- ГАРЫН АВЛАГА

The background features a white space with several vertical columns of three colored circles (orange, teal, purple) and stylized crosses. A large teal circle on the left has a teal cross on top. A large orange circle in the center has an orange cross on top. A large purple circle on the right has a purple cross on top. The text is centered over the teal and purple circles.

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙМЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЭДЛЭГ,
ХАНДЛАГА, ЧАДВАР ОЛГОХ ХИЧЭЭЛ

Өөрчлөлт миний гарт

- БАГШ НАРТ
- ЗОРИУЛСАН
- ГАРЫН АВЛАГА

2016 ОН
УЛААНБААТАР ХОТ



МОНЭС

Монголын Эмэгтэйчүүдийн Сан (МОНЭС) нь охид, эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэхийн төлөө Эмэгтэйчүүдийн сайн дурын бүлгүүдэд зориулж хөрөнгө босгож, буцалтгүй тэтгэлэг олгодог.

Дараах чиглэлээр тэтгэлэг олгодог.

- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалттай тэмцэх
- Шийдвэр гаргах түвшин дэхь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
- Эмэгтэйчүүдийн бүлгүүд, эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэх
- Эмэгтэйчүүдийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр ажилладаг.

“ӨӨРЧЛӨЛТ МИНИЙ ГАРТ”

жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, чадвар олгох хичээл

Санаачлагч: Монголын Эмэгтэйчүүдийн Сан (МОНЭС)

Зохиогч: Ч. Ундрах
Б. Ариунсанаа

Зөвлөх: Б. Оюунбилэг
М. Болормаа

Монголын Эмэгтэйчүүдийн Сан (МОНЭС)

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо
Бага тойруу, 48-р байр, 305 тоот

Утас: 77119991

Цахим шуудан: mones@mongol.net | info@mones.org.mn
admin@mones.org.mn

Нүүр хуудас: Mongolian Women's Fund

Энэхүү хичээлийн хөтөлбөрийг МОНЭС-ийн зөвшөөрөлгүйгээр хувилах, дахин хэвлэхийг хориглоно.

“ӨӨРЧЛӨЛТ МИНИЙ ГАРТ” хичээлийн хөтөлбөр болон багш нарт зориулсан гарын авлагыг **UN Trust fund**-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Ерөнхий Боловсролын Сургуулиудын өсвөр насны сурагчдад жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэгийг олгоход төрийн оролцоог нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд боловсруулав.



Монголын Эмэгтэйчүүдийн Сан(МОНЭС)-гийн санаачлага, UN Trust Fund-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Ерөнхий Боловсролын Сургуулиудын өсвөр насны сурагчдад жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэгийг олгоход төрийн оролцоог нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд “ӨӨРЧЛӨЛТ МИНИЙ ГАРТ” Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, чадвар олгох хичээлийн хөтөлбөрийг боловсруулж багш, сурагч Та бүхний гарт хүргүүлж байгаадаа таатай байна.

Аливаа хүчирхийлэлт харилцаа, зан үйлээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон ойр дотны хүмүүсээ хамгаалах боломж, чадвар бүгдэд бий. Харамсалтай нь түүнийг урьдчилан таньж мэдээгүйгээс, мөн чанарыг нь ухамсарлаж ойлгоогүйгээс үүдэж хүчирхийллийн хохирогч болох нь олон. Иймд энэхүү нөхцөл байдлаас сэргийлэх хамгийн үр дүнтэй бөгөөд найдвартай арга бол өөрийгөө болон бусдыг мэдээллээр хангах, мэдлэгтэй болгох, цаашлаад өөрөө болон бусдыг чадваржуулах явдал байдаг.

Хүчирхийлэл нь заяагдмал бус олж авсан зан үйл байдаг тул түүнийг өөрчлөх бүрэн боломжтой гэсэн байр сууринаас хандах нь юу юунаас илүү чухал юм. Тиймдээ ч энэхүү хичээлийн хөтөлбөрийн зорилго нь ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад жендэрийн талаарх хэвшмэл ойлголтын бидний амьдралд үзүүлэх нөлөөг зөв танин мэдсэнээр өөрийгөө найзыгаа сэргийлэх улмаар нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг эрэлхийлж байгаагаараа онцлог юм. Түүнчлэн жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх зөв мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэх нь урт хугацааны, тогтвортой сургалт, нөлөөллийн дүнд л биелэх боломжтой тул ЕБС-ийн сургалтын тогтолцоонд танилцуулах, нэвтрүүлэх оролдлого хийж байгаагаараа онцлог юм.

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН

ЗОХИОГЧИЙН ҮГ

Хичээлийн хөтөлбөр нь ЕБС-ийн 9-11р ангийн сурагчдын Жендэрт Суурилсан Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнд хандлага төлөвшүүлж, улмаар чадваржуулахад чиглэгдсэн.

Дараах 8 модуль хичээлийн хүрээнд 3-н жилийн туршид нийт 24 цаг заагдах хичээлийн хөтөлбөр юм.

Модуль 1: Хүний эрх

Модуль 2: Жендэр

Модуль 3: Хүчирхийлэл

Модуль 4: Жендэрт суурилсан хүчирхийлэл (жсх)

Модуль 5: Жсх-ийн үр дагавар


Модуль 6: Жсх-д хариу арга хэмжээ авах

Модуль 7: Жсх-с урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах

Модуль 8: Жсх-ийг таслан зогсоох

Хичээлийн хөтөлбөрийг ашиглахын өмнө дараах санамжийг толилуулж байна.

- 1 Хичээлийн хөтөлбөр нь дээр дурьдсан 8 модулиас бүрдэх бөгөөд ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад зориулагдан боловсрогдсон.
- 2 Хичээлийн хөтөлбөр нь багш нарт зориулсан гарын авлага болон сурагчдад зориулсан гарын авлагуудаас бүтсэн. Багшийн гарын авлагад нэмэлт унших материалыг багтааж харин сурагчдын гарын



авлага нь дасгал ажлын ном хэлбэрээр боловсруулагдаж, нэмэлтээр гэртээ үзэж судлах материал, дасгал, асуулт хариултыг багтаасан.

- 3 Хичээлийн хөтөлбөр нь сурагчдын суралцахуйг дэмжсэн зарчмаар хийгдсэн бөгөөд тэдний бие даан сурах, асуудалд дүн шинжилгээ хийх, бүлгээр хамтран ажиллах зэрэг эргэн санах түвшний чадвараас өргөн хүрээний чадамжийг зорьсон. Нөгөөтэйгүүр багш бүхий л хичээлийн турш мэдлэг олгогч бус идэвхижүүлэгч, чиглүүлэгчийн үүргээр оролцохоор боловсруулсан.
- 4 Төлөвлөсөн хичээлийн үйл ажиллагаа нь хичээлийн нэг цагт багтахгүй байх тохиолдолд гэрийн даалгавар, бие даалтад өгөх зэрэг уян хатан байдлаар багш зохицуулж болохыг анхаарна уу.
- 5 Хичээлийг дүгнэх үйл явц нь гол төлөв багшийн заах арга, дүн шинжилгээ хийх ур чадварт суурилсан тул хичээлийг заах багш Хүний эрх, Жендэр, ЖСХ-ийн асуудлаарх өөрийн ойлголт, мэдлэгээ гүнзгийрүүлж, аливаад хувь хүний байр суурь, үзэл бодлоор хандалгүй жендэрийн дэвшилтэт өнцөгөөр харах шаардлагатай болно. Иймд Багш нарт зориулсан гарын авлагад багтаасан нэмэлт мэдээллийг өөрийн болгож, сайтар ойлгох, нэмэн дэлгэрүүлж судлах шаардлагатай.

Хичээлийн хөтөлбөрийн агуулга болон аргачлалын тухай санал зөвлөмжийг доорх хаягаар зохиогч нарт илгээнэ үү.

Гарын авлага боловсруулсан

Ч. Ундрах, MHRP

Б. Ариунсанаа, MPH, MSW



ЕСДҮГЭЭР АНГИ

ГАРЧИГ

Модуль 1:	Хүний эрх <i>Хүн гэж хэн бэ? Эрх гэж юу вэ?</i>	14
Модуль 2:	Жендэр <i>Хүйс үү? Жендэр үү?</i>	24
Модуль 3:	Хүчирхийлэл <i>Хүчирхийлэл гэж юу вэ?</i>	22
Модуль 4:	Жендэрт Суурилсан Хүчирхийлэл <i>Жендэрт Суурилсан Хүчирхийлэл гэж юу вэ?</i>	34
Модуль 5:	Жендэрт Суурилсан Хүчирхийлэлийн үр дагавар <i>Найздаа туслах боломж надад бий юу?</i>	50
Модуль 6:	Жендэрт суурилсан хүчирхийлэлд Хариу арга хэмжээ авах <i>Би найздаа тусалж чадах уу?</i>	59
Модуль 7:	Жендэрт суурилсан хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, Өөрийгөө хамгаалах <i>Миний биеийн хаана хүрч болохгүй вэ?</i>	65
Модуль 8:	Жендэрт суурилсан хүчирхийлэлийг таслан зогсоох <i>Би хүчирхийлэлт бус харилцааг эрхэмлэж чадах уу?</i>	73



АРАВДУГААР АНГИ


Модуль 1:	Хүний эрх <i>Хүний эрх гэж юу вэ?</i>	08
Модуль 2:	Жендэр <i>Би хандлагаа өөрчлөх боломжтой юу?</i>	16
Модуль 3:	Хүчирхийлэл <i>Хүчирхийлэл ямар хэлбэрээр үйлдэгддэг вэ?</i>	24
Модуль 4:	Жендэрт Суурилсан Хүчирхийлэл <i>Сургуулийн орчинд жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэгддэг үү?</i>	34
Модуль 5:	Жендэрт Суурилсан Хүчирхийлэлийн үр дагавар <i>Сэтгэл зүйд ямар нөлөө үзүүлдэг вэ?</i>	36
Модуль 6:	Жендэрт суурилсан хүчирхийлэлд Хариу арга хэмжээ авах <i>Би найздаа тусалж чадах уу?</i>	48
Модуль 7:	Жендэрт суурилсан хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, Өөрийгөө хамгаалах <i>Надад ямар мэдрэмж төрдөг вэ?</i>	56
Модуль 8:	Жендэрт суурилсан хүчирхийлэлийг таслан зогсоох <i>Бид анги хамт олноороо юу хийж чадах вэ?</i>	64

Модуль 1:	Хүний эрх <i>Хүний эрхийг хэн, хэрхэн хамгаалах вэ?</i>	08
Модуль 2:	Жендэр <i>Би зориг гаргаж чадах уу?</i>	14
Модуль 3:	Хүчирхийлэл <i>Хүчирхийллээс сэргийлэхэд бид хэрхэн оролцох вэ?</i>	24
Модуль 4:	Жендэрт Суурилсан Хүчирхийлэл <i>Бид хүчирхийлэлгүй сургуулийг Бий болгож чадах уу?</i>	32
Модуль 5:	Жендэрт Суурилсан Хүчирхийлэлийн үр дагавар <i>Бид хүчирхийлэлгүй сургуулийг бий болгож чадах уу?</i>	36
Модуль 6:	Жендэрт суурилсан хүчирхийлэлд Хариу арга хэмжээ авах <i>ЖСХ-ийн тохиолдлыг хэрхэн мэдээлэх вэ?</i>	44
Модуль 7:	Жендэрт суурилсан хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, Өөрийгөө хамгаалах <i>Би өөрийгөө болон найзыгаа хамгаалж чадах уу?</i>	50
Модуль 8:	Жендэрт суурилсан хүчирхийлэлийг таслан зогсоох <i>Жендэрт суурилсан хүчирхийлэлгүй орчныг хэрхэн бий болгох вэ?</i>	56





АНХАН ШАТ



Хичээлийн сэдэв:

ХҮН ГЭЖ ХЭН БЭ?

ЭРХ ГЭЖ ЮУ ВЭ?

Үргэлжлэх хугацаа:

40 минут

Хэрэглэгдэх зүйлс:

Флипчарт цаас,

Маркер

Жижиг дөрвөлжин

хэмжээтэй цаас

(сурагчдын тоогоор)

Адил тэнцүү 2

өөр өнгийн жижиг

дөрвөлжин хэмжээтэй

цаас (сурагчдын

тоогоор)

Скоч

Хичээл заах

аргачлал:

Хөгжөөнт тоглоом

Хэлэлцүүлэг

Багшид зориулсан

мэдээлэл:

Хавсралт 9.1

“Хүний эрх”-тэй

холбоотой үндсэн

ойлголтууд

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

“Хүн гэж хэн бэ? Эрх гэж юу вэ?” сэдэвт хичээлийн гол зорилго нь хөгжөөнт тоглоом тоглуулах, сурагчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлэх замаар тэднийг “хүний үндсэн эрхүүд”-ийн талаарх анхан шатны, суурь ойлголттой болгоход оршино.

Энэхүү хичээлийг судалснаар:

- Хүний үндсэн эрхийн талаар анхан шатны ойлголттой болох,
- Хүний эрхийн шинж чанарын тухай мэдлэгтэй болох,
- Ялгаварлан гадуурхалт зэрэг хүний эрхийн зөрчлийн талаарх ойлголттой болох,
- Хүний эрхийг дээдлэх хариуцлагыг ухамсарлах

ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Д/д	ХИЙХ ЗҮЙЛ	ХУГАЦАА	АНХААРАХ ЗҮЙЛ
1.	Хичээлийн танилцуулга	5 мин	<i>“Хүний эрх гэж юу вэ?” сэдэвт хичээлийн зорилго, зорилт, үргэлжлэх хугацаа, заах аргачлалыг товч танилцуулах бөгөөд оролцооны аргачлалд тулгуурлан хичээлээ явуулна гэдгийг сурагчдад ойлгуулах,</i>
2.	Хөгжөөнт тоглоом	20 мин	<i>Хэлэлцүүлгийн явцад яригдаагүй, орхигдсон мэдээллүүдийг багш сурагчдад нэмж өгөх, Сурагчдын үзэл бодол, санаа, мэдрэмжид багш бэлтгэлтэй байх үүднээс мэдлэгээ цэгцэлж, хувийн бэлтгэлээ сайтар хангасан байх, Буруу ташаа мэдээллийг үнэн зөв болгох, бодит мэдээлэл өгөхөд анхаарах, Буруу ташаа мэдээллийг үнэн зөв болгох, бодит мэдээлэл өгөхөд анхаарах, Сурагчдын тэгш оролцоог хангах,</i>
3.	Ойлголт нэгтгэх	10 мин	<i>Сурагчдын ойлголт мэдлэгийг нэгтгэх үүднээс “хүний мөн чанар”, “хүний эрх” гэж юу болохыг ойлгомжтой, энгийн хэлээр тайлбарлаж ойлгуулах,</i>
4.	Хичээлийн дүгнэлт	5 мин	<i>Хичээлийн хүрээнд олж авсан шинэ мэдээлэл, мэдлэгээ нэгтгэн дүгнээд хичээлээ дуусгах,</i>

Үйл ажиллагаа 1.

ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Багш сурагчдад энэ удаагийн хичээлийн сэдэв болон зорилго, зорилтыг товчхон танилцуулна. “Хүн гэж хэн бэ?”, “Эрх гэж юу вэ?”, “Хүний эрх гэж юу вэ?” гэсэн асуултуудын хүрээнд хичээлээ заана гэдгийг сурагчдад хэлнэ. Мөн түүнчлэн хичээлийн дараа сурагчид ямар шинэ ойлголт, мэдлэгтэй болох талаар товч мэдээлэл өгнө.

Үйл ажиллагаа 2.

ШИНЭ АНГИ ХӨГЖӨӨНТ ТОГЛООМ

“Хүний мөн чанар”, “Хүний эрх”-ийн талаарх үндсэн ойлголт, мэдлэгийг бодит амьдрал дээр

мэдрүүлэх зорилгоор “Шинэ анги” хэмээх хөгжөөнт тоглоом тоглуулна. Мөн түүнчлэн хүний эрхийн зөрчил гэж юу болохыг ойлгуулахаас гадна эрх нь зөрчигдсөн хүмүүст ямар мэдрэмж төрдөг болохыг сурагчдад бодитоор мэдрүүлнэ.

БЭЛТГЭЛ:

- *Багш сурагч бүрт жижиг дөрвөлжин хэмжээтэй 3 ширхэг наадаг цаас тарааж өгнө.*
- *Хамгийн сайн мэддэг, тэдний өдөр тутмын амьдралд хэрэглэгддэг 3 эрхийг сонгон авч, тарааж өгсөн 3 ширхэг цаасан дээр нэг, нэг эрхийг том, гаргац, бусдад унишгдахуйц бичихийг хүснэ. /амьд явах, аюулгүй байх, сурч боловсрох гэх мэт/*
- *Багш хөгжөөнт тоглоомын явцад хэрэглэгдэх 2 өөр өнгийн жижиг дөрвөлжин хэмжээтэй цаасыг оролцогчдын тоонд тохируулан адил тэнцүү өгөхөөр урьдчилан бэлтгэсэн байна.*
- *Тоглоомын дүрмийг сурагчдад танилцуулж, тоглоомыг эхлүүлнэ. Багш уг тоглоомын гол чиглүүлэгч нь байна.*

ТОГЛООМЫН ДҮРЭМ:

Эхлэл

- *Багш өөрийгөө шинээр бүрдсэн ангийн багш хэмээн төсөөлнө.*
- *Багш сурагчдад өөрсдийгөө шинээр байгуулагдсан сургуулийн, бие биенээ огт танихгүй, өмнө нь харж байгаагүй сурагчид гэж төсөөлөхийг хүснэ.*
- *Шинэхэн сурагчидтайгаа мэндэлж, өөрийгөө товчхон танилцуулна.*
- *Багш өөрийгөө тэрхүү “шинэ анги”-ийн багш гэж хэлээд зөвхөн багш л бүх шийдвэрийг гаргаж, багшийн гаргасан шийдвэрийг хэн ч эсэргүүцэх боломжгүй бөгөөд багшийн шийдвэрийг үг дуугүй биелүүлэх үүрэгтэй гэдгийг сурагчдад сануулна.*
- *Багш ангийнхаа хүүхдүүдийг бие биедээ тустай, нөхөрсөг, аз жаргалтай байгаасай гэж хүсдэг учраас ангидaa дүрэмтэй болно гэдгийг сурагчдад хэлнэ.*
- *Ангийн эхний дүрмийг танилцуулна.*

Нэгдүгээр дүрэм

- *Багш сурагч бүрт 3 ширхэг наадаг цаас тарааж өгнө. Цаас тус бүрт өөрт хамгийн чухал, эрхэм гэж боддог 3 эрхийг нэг нэгээр нь тод, гаргацтай бичиж, энгэртээ наахыг хүснэ.*

- Ингэснээр багш өөрийн ангийн сурагчиддаа хүссэн эрхийг нь өгч байна гэдгийг тайлбарлана.
- Сурагчид хүссэн 3 эрхүүдээ бичиж дууссаны дараа бие биетэйгээ дотно танилцаж, яагаад тэрхүү 3-н эрхийг сонгосон шалтгаанаа танилцсан найзууддаа товч тайлбарлахыг хүснэ.
- Найзуудтайгаа танилцахад 3 минутын хугацаа зарцуулна. Улмаар танилцах хугацаа дууссаныг мэдэгдэж, бүх сурагчдыг багшид анхаарлаа хандуулахыг хүснэ.
- Багш ангидаа дахин өөр нэг шинэ дүрэм тогтоох шаардлагатай болсныг сурагчиддаа хэлж, 2-р дүрмийг танилцуулна.

Хоёрдугаар дүрэм

- Сурагч бүр өөрт байгаа эрхээ эдлэх гээд шинэхэн ангид бага зэрэг эмх замбараагүй байдал үүссэн учраас ангид өөр дүрэм шаардлагатай болсон гэдгийг багш сурагчдад хэлнэ.
- Урьдчилан бэлтгэсэн 2 өөр өнгийн цааснаас аль дуртай өнгөө сонгохыг шинэхэн ангийн сурагчдаас хүснэ. Сурагч бүр аль нэг өнгийн цаас сонгосон байх шаардлагатай болохыг анхаараарай!
- Ингээд сурагчдыг сонгосон өнгийн дагуу ангийн зүүн болон баруун хэсэгт хуваагдаж зогсохыг хүснэ. Улмаар ангийг 2 бүлэгт хувааж байгааг хэлээд бүлгийн гишүүддээ тустай, нөхөрсөг хандаж байхыг уриална.
- Хэдийгээр 2 бүлэгт хуваагдсан ч өмнөхтэй ижил адил тэгш эрхтэй болохыг сануулж бүлгийн гишүүдийг хоорондоо танилцахыг уриална. Бүлгүүдийн танилцах ажиллагаа 3 минут үргэлжилнэ. Хугацаа дууссаныг мэдэгдэж, багшид анхаарлаа хандуулахыг бүлгүүдээс хүснэ.
- Багш ангидаа дахин өөр нэг шинэ дүрэм тогтоох шаардлагатай болсныг сурагчиддаа хэлж, 3-р дүрмийг танилцуулна.

Гуравдугаар дүрэм

- Ангидаа дахин өөр нэгэн дүрэм тогтоох шаардлагатай болсныг мэдэгдэнэ.
- А өнгийн баг Б өнгийн багаас давуу эрхтэй болохыг мэдэгдэж, А багийн сурагчид Б багийн сурагчдын эрхийг авах бүрэн эрхтэй болохыг сануулна. Мөн түүнчлэн Б багийн сурагчид эрхээ өгөхгүй байхын тулд ямар ч арга хэрэглэж болохыг хэлнэ.
- Харин А багийн гишүүн Б багийн гишүүний эрхийг ямарваа нэгэн аргаар авахыг оролдох ба Б

багийн гишүүн бүрийн бүх эрхийг авахыг хичээх хэрэгтэйг ойлгуулна.

- А багт бүх эрхээ алдсан Б багийн гишүүд тоглоомоос хасагдана гэдгийг ойлгуулна.
- Гэхдээ А багийн 1 гишүүн Б багийн 1 л гишүүний эрхийг авах эрхтэй ба 1-с илүүг авах ёсгүй юм. Өөрөөр хэлбэл өөр өөр гишүүний эрхүүдийг нэг, нэгээр нь авах ёстой болно.
- Энэхүү дүрмийг баримтлах хугацаа 5 минут байна.
- Хугацаа дууссангуут тоглоомыг мөн адил дуусгаж сурагчдыг тойрог болгон суулгана.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:

- “Шинэ анги” хөгжөөнт тоглоомын талаар сурагчдад ямар сэтгэгдэл, мэдрэмж, эргэцүүлэл төрж байгааг олж мэдэхийн тулд “Сурагчийн гарын авлага” дээрх
- **Дасгал 1**-ийг ажиллуулах замаар дор өгөгдсөн асуултуудын дагуу хэлэлцүүлэг өрнүүлнэ. Хүүхэд тус бүрийн хариултыг нэг бүрчлэн сонсох боломжгүй тул нэг багаас 2-оос илүүгүй хүүхдээр товч яриулна.

ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТУУД

- Хүн бүр хүссэн 3-н эрхээ авахад ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ?
 - Та нарыг 2 бүлэгт хуваахад ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ?
 - А багийн гишүүдээ! Та нарт Б багийн гишүүдээс давуу эрх мэдэл өгөхөд ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ?
 - Б багийн гишүүдээ! А багийн гишүүд та нараас давуу эрх тэдэлтэй гэж хэлэхэд ямар санагдсан бэ? Эрхийг чинь хэзээ л бол хэзээ хурааж авах аюул дор амьдрах ямар байсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ?
 - А багийнхаан! Б багийн гишүүдийн эрхийг авах ямар байсан бэ? Хялбар байв уу? Хэцүү байв уу?
 - Б багийнхаан! А багийнханд эрхээ алдахгүйн тулд ямар арга хэмжээ авсан бэ?
- Нэг хүүхдэд төрсөн сэтгэгдэл бусад хүүхдүүдэд төрсөн эсэхийг асууж мэднэ. Бүх хүүхдэд адил мэдрэмж төрсөн эсэх? Бусдаас өөр, онцгой саналтай хүүхэд байвал Яагаад? гэдгийг тодруулж асуух замаар хэлэлцүүлгээ идэвхжүүлнэ.
 - Хүүхдүүдэд төрсөн мэдрэмж, санаа зэргийг цаасан самбарт буулгана. Энэ нь хичээлээ тайлбарлах, дүгнэх болон эргэж санахад тустай.

- Сурагчдыг аливаад өөрийн нүдээр дүн шинжилгээ хийх чадварт сургах үүднээс “Сурагчийн гарын авлага” дээрх Дасгал 2-ыг бие дааж ажиллуулах замаар хэлэлцүүлгийг идэвхжүүлнэ. Ингэхдээ “Шинэ анги” тоглоом дээрх ангийн багшийг “нийгэм” хэмээн төсөөлөхийг сурагчдаас хүснэ. Хичээлийн цаг хангалттай хүрэлцэхгүй тохиолдолд гэрийн даалгаварт уг дасгалыг ажиллуулах боломжтойг анхаараарай!

ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТУУД

- *Сурагч бүр бидний эдэлж байсан шиг 3 эрхтэй байх ёстой юу?*
- *Бидний амьдарч буй нийгэмд хүмүүс өөр өөр бүлгүүдэд ийнхүү хуваагдсан, “ангилагдсан” байдаг уу?” (Хэрэв “хүйсээр” буюу “эрэгтэй, эмэгтэйгээр ангилагддаг, ялгагддаг” гэж дурдагдахгүй бол үүнийг нэмж хэлээрэй.)*
- *Нийгэм нэг бүлэг хүмүүст өөр бүлэг хүмүүсээс илүү эрх мэдэл өгөх нь ямар үр дагавартай вэ?*
- *Нийгэм ийнхүү зарим хүмүүст илүү их эрх мэдэл олгох нь шударга уу?*
- *Манай нийгэм ихэвчлэн хэнд, ямар бүлэг хүмүүст илүү эрх мэдэл олгодог вэ?*
- *Зарим хүмүүс энэ эрх мэдлээ бусдын эрхийг үл хүндэтгэх, бусдыг дарамтлахад ашигладаг уу?*

Үйл ажиллагаа 3.

ОЙЛГОЛТ НЭГТГЭХ

Багш Хавсралт 1-д байгаа нэмэлт мэдээлэлтэй сайтар танилцаж, өөрийн болгоно. Улмаар “Шинэ анги” хөгжөөнт тоглоомын дараа сурагчдын дунд өрнүүлсэн хэлэлцүүлгийн үеэр яригдаагүй, орхигдсон санаануудыг сурагчдад хэлж өгөхөөс гадна “хүний эрх”-тэй холбоотой дараах үндсэн ойлголтыг лекцийн аргаар урьдчилан бэлтгэсэн танилцуулга ашиглах замаар сурагчдад өгч болно. Мөн түүнчлэн танилцуулгаа баяжуулахын тулд Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон МУ-ын Үндсэн Хуулийн 16-р зүйлтэй танилцаарай!

- Хүн гэж хэн бэ?
- Эрх гэж юу вэ?
- Хүний эрх гэж юу вэ?
- Хүний эрхийг зөрчих гэж юу вэ?



Үйл ажиллагаа 4.

ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

Хичээлийн дүгнэлт хэсэгт сурагчдад дараах үндсэн мэдээллийг өгөхөөс гадна “Шинэ анги” хөгжөөнт тоглоомын үеэр яригдаагүй, орхигдсон мэдээллийг багш нэмж хэлнэ. Сурагчдын нас, биеийн хөгжлийн онцлогт тохируулан энгийн ойлгомжтой хэлээр, жишээ ашиглан тайлбарлахын тулд багш урьдчилан өөрийгөө сайтар бэлтгэсэн байхыг анхаарна уу!

- *Бүх хүмүүс эрх тэгш байхаар заяагдсан бөгөөд хүний бүх эрх нэг нь нөгөөгийнхөө дээр, эсхүл доор гэж байхгүй. Тэгэхээр хүний эрх бол тэгш, шударга, ялгаваргүй, түгээмэл, салшгүй, хуваагдашгүй, харилцан өөр хоорондоо хамааралтай юм.*
- *Нас, хүйс, гарал угсаа зэргээс үл шалтгаалан хүн бүрт адил тэгш эрх байдаг. Надад байдаг эрх миний найзад ч яг адилхан байдаг. Жишээ нь, дээд ангийн ах надаас насаар ах/эгч учраас намайг дээрэлхэж болно, харин би доод ангийн хүүхдүүдээс ах/эгч учраас тэднийг дарамталж болно гэж бодох нь буруу.*
- *Аль нэг эрх нөгөөгөөс илүү, эсвэл дутуу биш. Тухайлбал, би сургуульд сурч л байвал намайг бусад хүмүүс дээрэлхэж, зодож болно гэсэн ойлголт байж болохгүй. Өөрөөр хэлбэл, миний сурч боловсрох эрх хангагдаж байвал хүчирхийлэл дарамтаас ангид байх эрх зөрчигдсөн ч хамаагүй гэж ойлгох нь буруу.*
- *Миний эрх өөр хэн нэгний эрхээс дээгүүр эсхүл доогуур байна гэж байдаггүй. Өөрөөр хэлбэл, А-гийн гэр бүл чинээлэг учраас А магтуулж, сайшаагдана, Б-гийнх дундчуул учраас Б-г үл тоомсорлож болно гэсэн ойлголт буруу бөгөөд энэ нь ялгаварлаж байгаа хэлбэр юм. Хэрэв хэн нэгэн бусдыг ялгаварлаж байвал энэ нь хүний эрхийг зөрчиж байгаа хэрэг болно.*
- *Ялгаварлан гадуулхалт бол хүний эрхийн ноцтой зөрчил юм. Бусдыг насаар нь, хүйсээр нь, ямар айлын хүүхэд гэдгээр нь, ээж аавынх нь эрхэлж буй ажлаар нь, ямар хувцас өмссөнөөр нь, ямар сурдагаар нь ялгаатай харьцаж болохгүй.*
- *Бусдыг үл хүндэтгэж байна гэдэг бол бусдын эрхийг зөрчиж байна гэсэн үг. Иймд хэн ч миний мөн бусдын эрхийг зөрчих ёсгүй. Өөрөөр хэлбэл би хичээл дээр ярих эрхтэй ч бусдын сонсох эрхийг зөрчиж болохгүй. “Өөрийгөө хүндлүүлэхийг хүсвэл бусдыг хүндэл” гэсэн үг бий.*
- *Хүн бүрт адил тэгш эрхүүд байдгийн адил үүрэг хариуцлага гэж байдаг. Тухайлбал, Би бусдын эрхийг зөрчвөл түүнийхээ хариуцлагыг хүлээнэ. Энэ бол миний үүрэг хариуцлага юм гэдгийг энгийнээр тайлбарласнаар хичээл дуусна.*

ХҮНИЙ ЭРХ-ТЭЙ ХОЛБООТОЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

1. ХҮН гэж хэн бэ?

Хүний төрөлх мөн чанар юу вэ?

Онцгой чадамжууд болон үнэ цэнэ гэж юу вэ?

Хүн бол биологийн бүтээгдэхүүн	Хүн бие махбодтой	Гар, хөл, толгой, бие гээд байгалийн амьтан юм. Хэдийгээр “хүн”-ий бүлэгт багтах ч цорын ганц, дахин давтагдашгүй байгалийн бүтээгдэхүүн хэмээн тооцогддог. Хүн төрж, өсөж, хөгширч, үхдэг байгалийн хуулинд захирагдана.
	Хүн оюун ухаантай	Унших, бичих, бодох, сэтгэх, хэл яриагаараа бусадтай ойлголцох, мөрөөдөх, түүндээ тэмүүлэх, бүтээх төдийгүй өөрийгөө хянах, хязгаарлах гэх мэт чадамжтайгаараа ялгаатай.
	Хүн зүрх сэтгэлтэй	Дотоод сэтгэлээсээ бусдыг хайрлах, хүндлэх, баярлах, гуних гэх мэт мэдрэмжтэй байдгаараа онцлогтой.

Жич: Хамгийн ухаантай амьтанд ч энэ онцгой чадвар байхгүйг хэлнэ. Хамгийн энгийнээр хүн - эрэгтэй, эмэгтэй гэж ангилагддаг ч хүүхэд гэж бас ангилж авч үздэг.

2. ЭРХ гэж юу вэ?

Эрх гэж дээрх Хүний төрөлх бие даасан мөн чанарт тулгуурлан баталгаатай байхыг хэлнэ.

Хүн бол нийгмийн бүтээгдэхүүн	Амьдрах	Оршин тогтнож аж төрөх
	Халдашгүй байх	Өөрийн бүрэн бүтэн байдлаа хадгалах
	Эрхэмсэг байх	Нэр төр, үнэ цэнээ мэдрэх, адил тэгш, эрхэм байх
	Эрх чөлөөтэй байх	Өөрийнхөө амьдралыг өөрөө зохиох ба өөрөө сонголт хийж шийдвэрээ гаргах ингэхдээ бусдын сонголт шийдвэрийг үгүйсгэхгүй. Харин насанд хүрээгүй хүүхдийн хувьд заавал аав ээжтэйгээ зөвлөсөн байна.

3. ХҮНИЙ ЭРХ гэж юу вэ?

ХҮНИЙ ЭРХ бол хаана амьдарч байгаагаасаа үл хамааран бүхий л эрх, эрх чөлөөг аливаа **ялгаварлан гадуурхалтгүйгээр** эдлэх ёстой. /нас, хүйс, хэл, арьсны өнгө, угсаа гарал, шашин шүтлэг гэх мэт/ Өөрөөр хэлвэл дээрх 2 бүлэг өгөгдөлийг нэгтгэн дүгнэх байдлаар тайлбарлаж өгнө.

Хичээлийн сэдэв:

ХҮЙС ҮҮ? ЖЕНДЭР ҮҮ?

Үргэлжлэх хугацаа:

40 минут

Хэрэглэгдэх зүйлс:

Флипчарт цаас

Маркер

Хичээл заах аргачлал:

Асуулт, хариулт

Дасгал ажил

Багшид зориулсан

мэдээлэл:

Хавсралт I-2

“Жендэрт”-тэй

холбоотой

зарим түгээмэл

нэр томъёоны

тодорхойлолт



ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү хичээлийн гол зорилго нь “ХҮЙС”, “ЖЕНДЭР” хэмээх нэр томъёоны талаарх сурагчдын мэдлэгийг тэлж, тэдгээрийн хоорондын ялгааг таньж ойлгодог болгохоос гадна нийгмээс эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдэд оноосон жендэрийн хэвшмэл дүрийн тухай анхан шатны ойлголтыг өгөхөд оршино.

Хичээл нь дараах зорилттой.

- Сурагчид хүйс болон жендэрийн хоорондын ялгааг тодорхойлж чаддаг болох,
- Жендэрийн хэвшмэл ойлголтын талаар мэдлэгтэй болгож, эерэг хандлага төлөвшүүлэх,

ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Д/д	ХИЙХ ЗҮЙЛ	ХУГАЦАА	АНХААРАХ ЗҮЙЛ
1.	Хичээлийн танилцуулга	5 мин	"Хүйс үү? Жендэр үү?" сэдэвт хичээлийн зорилго, зорилт, үргэлжлэх хугацаа, заах аргачлалыг товч танилцуулах бөгөөд оролцооны аргачлалд тулгуурлан хичээлээ явуулна гэдгийг сурагчдад ойлгуулах,
2.	Хөгжөөнт тоглоом	15 мин	Хөгжөөнт тоглоом нь хүйс болон жендэрийн талаар сурагчдын ойлголт, мэдлэгийг тандаж мэдэхэд чухал ач холбогдолтой байх тул тоглоомын явцад багш сурагчдын хийж буй алхамд анхаарлаа хандуулах,
3.	Дасгал ажил	15 мин	Дасгал ажил бол энэхүү хичээлийн хамгийн чухал хэсэг учир багш өөрийгөө урьдчилан сайтар бэлтгэсэн байх, Түүнчлэн багш жендэрийн дэвшилтэт ойлголт, үзэл хандлагыг өөртөө төлөвшүүлсэн байх,
4.	Хичээлийн дүгнэлт	5 мин	Хичээлийн хүрээнд олж авсан шинэ мэдээлэл, мэдлэгээ нэгтгэн дүгнээд хичээлийг дуусгах,

Үйл ажиллагаа 1.

ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Багш сурагчдад энэ удаагийн хичээлийн сэдэв, зорилго, зорилтыг товчхон танилцуулж, өмнөх "Хүн гэж хэн бэ? Эрх гэж юу вэ?" сэдэвт хичээлтэй уялдаа, холбоотой болохыг ойлгуулна.

Түүнчлэн хичээлийн дараа хүйс болон жендэр хэмээх ойлголтын ялгаатай талуудыг таньж мэддэг болохоос гадна жендэрийн хэвшмэл ойлголт гэж чухам юу болох талаар суралцаж, өөрсдийн хэвшмэл ойлголтоо дэвшилтэт ойлголт болгон өөрчлөх боломж байгааг сурагчдад сануулна.

Үйл ажиллагаа 2.

ХҮЙСИЙН ҮҮ? ЖЕНДЭРИЙН ҮҮ? ХӨГЖӨӨНТ ТОГЛООМ

Багш сурагчдын дунд “Хүйсийн үү? Жендэрийн үү?” хэмээх хөгжөөнт тоглоом тоглуулна. Энэхүү тоглоомыг тоглосноор сурагчид аливаа асуудлыг хүйсийн эсвэл жендэрийн талаас нь ялгаж, салгаж харах, өөрийн байр сууринаас дүн шинжилгээ хийхэд суралцахаас гадна жендэрийн хэвшмэл үзэл хандлагатай холбоотой зарим асуудалд дэвшилтэт өнцөгөөс харах боломжтой болох юм. Мөн түүнчлэн багш хүүхдүүдийнхээ хүйс болон жендэрийн талаарх ойлголт, мэдлэг ямар түвшинд байгааг олж мэдэх боломжтой болох юм. .

а. Тоглоомын зааварчилгаа

- Багш бүх сурагчдыг суудлаасаа босч нэг эгнээ болон жагсаж зогсохыг хүснэ. Эгнээ болон зогссоныхоо дараа хүүхдүүд нүдээ анина. Багшийг “нүдээ нээгээрэй!” гэж хэлэх хүртэл бүгд нүдээ аних ёстойг сануулна. Тоглоомын туршид хүүхдүүд урагш, хойш хэд хэдэн алхам хийх тул хичээлийн анги танхим чөлөөтэй байх шаардлагатайг анхаарна уу!
- Багш “хүйс” болон “жендэр”-тэй холбоотой дараах 10 өгүүлбэрийг нэг нэгээр нь ээлж дараалан уншина. Хэрэв хүүхдүүд тухайн өгүүлбэрийг “жендэрийн” хэмээн бодож байгаа бол УРАГШАА, “хүйсийн” гэж бодож байгаа бол ХОЙШОО нэг удаа алхана гэдгийг сануулна.

ӨГҮҮЛБЭРҮҮД

1. Охид уян зөөлөн, даруу байдаг. (Ж)
2. Шилжилтийн насанд хөвгүүдийн дуу хоолой нь бүдүүрч, сахал ургаж эхэлдэг. (Х)
3. Зөвхөн охид л гэр цэвэрлэх, хоол хийх, аяга таваг угаах ажилд анхаарах үүрэгтэй. (Ж)
4. Хөвгүүд, эрэгтэйчүүд БЗДХ-т өртөх эрсдэл өндөр байдаг. (Ж)
5. Эмэгтэй хүн жирэмсэлж, хүүхэд төрүүлдэг. (Х)
6. Шилжилтийн насны хөвгүүдэд нойтон зүүд үзэгддэг. (Х)
7. Хөвгүүд гэр бүлээ тэжээх чадвартай, мөнгө сайн олдог эр хүн болж өсөх хэрэгтэй. (Ж)
8. Охидод сарын тэмдэг ирдэг. (Х)
9. Эр хүн уйлдаггүй. (Ж)
10. Хөвгүүд, эрэгтэйчүүд хүчирхэг, чадалтай. Харин охид, эмэгтэйчүүд сул дорой байдаг. (Ж)

6. Ойлголтоо нэгтгэх нь

- Багш бүх өгүүлбэрийг уншиж дууссаны дараа сурагчдыг нүдээ нээж бие биенээ хаана зогсож байгааг харахыг хүснэ. Хүүхдүүд өөр өөр байрлалд зогссон байх ба энэ нь бүгд хүйс болон жендэрийн талаар өөр өөр ойлголттой байгааг илтгэж байгаа гэдгийг тайлбарлана. Иймд ойлголтоо нэгтгэхийн тулд өгүүлбэр бүрийн талаар сурагчидтай ярилцаж, тэдний үзэл бодлыг нь сонсоорой!
- Ойлголт нэгтгэх ярилцлагын дараа Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 1-ийг бие даан ажиллаж, зөв хариултыг сонгох даалгавар өгнө.

Үйл ажиллагаа 3.

ХҮҮ БОЛОХ УУ? ОХИН БОЛОХ УУ? ДАСГАЛ АЖИЛ

“Хүү болох уу? Охин болох уу?” хэмээх энэхүү дасгалыг ажиллуулах замаар сурагчдын хүйс болон жендэрийн талаарх өмнөх хөгжөөнт тоглоомын хүрээнд олж авсан ойлголт мэдлэгийг бататгахаас гадна хоорондын ялгаатай байдлыг таниулна.

а. Дасгал ажлын зааварчилгаа

Уг дасгалыг ажиллуулахдаа багш сурагчдыг эрэгтэй эрэгтэй, эмэгтэй эмэгтэйгээр нь (ижил хүйсээр нь) хос болгон суулгаж дараах 2, 2 өгүүлбэрүүдийн талаар хоорондоо ярилцаж, Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 2 хэсэгт гүйцээж бичих даалгавар өгнө. Ингэхдээ сурагчдын хүйсээс хамаарч өгүүлбэр гүйцээх даалгавар нь өөр өөр байхыг анхаараарай!

Охидод...

- *Би эмэгтэй хүүхэд болж төрсөндөө баяртай байдаг. Яагаад гэвэл...*
- *Би эрэгтэй хүүхэд байсан ч болоосой гэж боддог. Яагаад гэвэл...*

Хөвгүүдэд...

- *Би эрэгтэй хүүхэд болж төрсөндөө баяртай байдаг. Яагаад гэвэл...*
- *Би эмэгтэй хүүхэд байсан ч болоосой гэж хүсдэг. Яагаад гэвэл...*

Гүйцээж бичсэн өгүүлбэрээ сайн дураараа найзууддаа уншиж танилцуулах сурагч байгаа

эсэхийг асууна. Дор хаяж 10 өөр утга санаа бүхий хариултыг самбарт жагсаан бичнэ. Сурагчид давтагдсан санаа бүхий хариулт өгч болохыг анхаараарай! Хэрэв сайн дураараа унших сурагч байхгүй тохиолдолд ямар нэгэн тоглоомын аргаар сурагчдын идэвхийг нэмэгдүүлж болно. Гэхдээ хичээлийн цаг хүрэлцэх эсэхэд анхаараарай!

САНАЛ БОЛГОЖ БУЙ ТОГЛООМ

“АЛЧУУР ХАЯХ” тоглоомын аргачлалыг ашиглах боломжтой. Сурагчдыг тойрог хэлбэрт оруулан, дотогш харуулан суулгана. Багш санамсаргүйгээр нэг сурагчийг сонгож, тоглоомыг эхлүүлэхийг хүснэ. Тойрогт байгаа бүх сурагчид нүдээ анин суух ёстой бөгөөд сонгогдсон нэг сурагч тойргийн гадуур алчуур барин алхах явцдаа бусдад мэдэгдэлгүйгээр хүссэн хүүхдийн ард алчуураа унагаагаад тойрогт буцаж сууна. Багш хүүхдүүдэд “нүдээ нээх” дохио өгсний дараа тойрогт суугаа хүүхдүүд бүгд нүдээ нээж, ардаа алчуур байгаа эсэхийг шалгана. Ард нь алчуур унасан сурагч өөрийн өгүүлбэрээ унших зарчмаар дасгалыг үргэлжлүүлнэ.

Энэхүү дасгал ажлын дүнд хүүхдүүд өөрийн болон эсрэг хүйсийнхээ давуу болон сул талын талаар дүгнэн бодох боломжтой болох юм. Тухайлбал, охид эмэгтэй хүүхэд байхын давуу тал, харин хөвгүүд охин байсан бол юу нь илүү сайхан, гоё байх талаар эргэцүүлж бодно гэсэн үг. Сурагчид янз бүрийн сонирхолтой хариулт өгөх ба тухайлбал дараах байдлаар өгүүлбэрийг гүйцээсэн байж болно.

БОЛОМЖИТ ХАРИУЛТУУД

Би охин байсан ч болоосой. Учир нь би хүүхэд төрүүлэх боломжтой (хүйсийн) байх байсан.

- *Би эрэгтэй болохоор аз жаргалтай байдаг. Яагаад гэвэл би хэзээ ч хог асгахгүй, гэрийн ажил хийхгүй (жендэрийн) шүү дээ.*

Багш хүүхдүүдийн өгч буй хариултуудыг бүгдийг самбарт жагсаан бичнэ. Мөн түүнчлэн хүүхдүүд Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 2-ын ТЭМДЭГЛЭЛ хэсэгт найзуудынхаа хэлж буй хариултуудыг жагсаан бичих хэрэгтэйг сануулна.

Сурагчдын өгсөн хариултуудаас зөвхөн охид болон хөвгүүд, мөн түүнчлэн аль аль хүйсийн хүүхдүүдэд хамаатай байх тус бүр 1, 1 өгүүлбэрийг багш сонгон авч сурагчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлнэ. Ингэхдээ дараах чиглүүлэх асуултуудыг ашиглана.

ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТУУД

- *Аль нь зөвхөн охидод хамааралтай вэ? Яагаад*
- *Аль нь зөвхөн хөвгүүдэд хамааралтай вэ? Яагаад*
- *Аль өгүүлбэр нь охид болон хөвгүүдэд аль алинд нь хамааралтай вэ? Яагаад*

Хичээлийн цагт багтааж зөвхөн 3-н хариултын талаар ярилцах бөгөөд жагсаалтад буй үлдсэн хариултуудын талаарх өөрийн бодлоо гэртээ гүйцээж ирэх буюу Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 3 буюу “Миний бодлоор...” хэмээх дасгалыг гэртээ ажиллаж ирэх даалгавар өгнө.

6. Дасгалыг бататгах нь

Уг дасгал ажлыг хийж дууссаны дараа багш сурагчдад тайлбар өгч, аль нь хүйстэй хамааралтай ойлголт, харин аль нь жендэртэй хамааралтай ойлголт болох тухай үндсэн ойлголтыг өгч, хүйс болон жендэрийн хоорондын ялгааг хүүхдүүдэд ойлгомжтой, энгийн байдлаар тайлбарлаж өгнө. Үүнтэй уялдуулан эрэгтэй эмэгтэй хүмүүст нийгмээс оноосон жендэрийн хэвшмэл дүрийн талаар жишээ ашиглан товч мэдээлэл өгнө. Тухайлбал, гэр цэвэрлэх, анги танхимаа цэвэр цэмцгэр байлгах нь зөвхөн охидын үүрэг биш юм. “Цэвэрлэгээний ажил бол зөвхөн охидын хийх ёстой ажил” гэсэн ойлголт нь охидод нийгмээс оноосон “жендэрийн хэвшмэл дүр” юм. Охид, хөвгүүд хамтран ашиглаж буй анги танхимаа цэвэрлэх, цэвэр цэмцгэр байлгах нь охид, хөвгүүдэд аль алинд нь хамааралтай гэх мэт амьдралд нь хамгийн ойр байх жишээ авч тайлбарлахыг хичээнэ.

Эцэст нь багш сурагчдаас дасгал ажлын талаарх санал сэтгэгдлийг нь сонсож, хүйс болон жендэрийн дараах тодорхойлолтыг хэлж өгнө.


ТОДОРХОЙЛОЛТ	ТОДОРХОЙЛОЛТ
<p>Хүйс гэдэг бол эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын байгалиас заяасан биологийн ялгааг илэрхийлдэг. Мөн түүнчлэн хүйс нь охид, хөвгүүдийн бие махбодийн ялгаатай байдлыг харуулдаг. Тухайлбал, эмэгтэй хүн жирэмсэн болж, хүүхэд төрүүлдэг. Харин эрэгтэйчүүд жирэмслэх, хүүхэд төрүүлэх боломжгүй. Өөрөөр хэлбэл хүйсээс хамааралтай биологийн ялгаа байгалаас заяатай.</p>	<p>Жендэр гэдэг бол хүйсийн талаархи нийгмийн үзэл. Тухайлбал, охид, хөвгүүдийг юу хийх, ямар мэргэжилтэй болох, хэрхэн биеэ авч явах, ямар хувцас өмсөх, ямар ааш зантай байх тухай тогтсон ойлголтыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл хөвгүүд инженер болдог, охид багш эсвэл сувилагч болдог гэсэн ойлголт нь нийгмээс оноосон жендэрийн үзэл юм.</p>

Үйл ажиллагаа 4.

ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

“Хүйс үү? Жендэр үү?” хэмээх энэхүү хичээлийн хүрээнд багш сурагчдад дараах гол мэдээллийг өгөхийг зорино.

- Хүйс гэдэг бол эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын байгалиас заяасан биологийн ялгааг илэрхийлдэг. Мөн түүнчлэн хүйс нь охид, хөвгүүдийн бие махбодийн ялгаатай байдлыг харуулдаг. Тухайлбал, эмэгтэй хүн жирэмсэн болж, хүүхэд төрүүлдэг. Харин эрэгтэйчүүд жирэмслэх, хүүхэд төрүүлэх боломжгүй. Өөрөөр хэлбэл хүйсээс хамааралтай биологийн ялгаа байгалаас заяатай.
- Жендэр бол хүйсийн талаархи нийгмийн үзэл. Тухайлбал, охид, хөвгүүдийг юу хийх, ямар мэргэжилтэй болох, хэрхэн биеэ авч явах, ямар хувцас өмсөх, ямар ааш зантай байх тухай тогтсон ойлголтыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл хөвгүүд инженер болдог, охид багш эсвэл сувилагч болдог гэсэн ойлголт нь нийгмээс оноосон жендэрийн үзэл юм.
- Жендэрийн тэгш байдлын үүднээс бол хэн ч инженер болж болно, хэн ч багш эсвэл сувилагч болох боломжтой. Бидний амьдарч буй нийгэм, соёл, орчин нь жендэрийн хэвшсэн ойлголтыг бий болгосон байдаг ба жендэрийн хүйсээс ялгагдах тал нь өөрчлөгдөх боломжтой байдаг. Нийгмээс жендэрийн хэвшмэл дүрүүдийг охид, хөвгүүдэд тулгаж байдаг тул хорио, тээг болох нь олонтоо. Охид гэр цэвэрлэх, харин хөвгүүд гэр цэвэрлэх,



хог асгах ёсгүй гэх мэт. Энэ бол нийгмээс эрэгтэй эмэгтэй хүмүүст тулгасан жендэрийн хэвшмэл дүр юм. Энэ ойлголтыг өөрчлөх бүрэн боломжтой.

- Жендэр нь нийгмийн харилцаан дунд нөхцөлддөг ойлголт тул түүхэн хөгжлийн үед өөрчлөгдсөөр иржээ. Эрт дээр үед эрэгтэй хүн өрхийг тэжээгч (ан агнах гэх мэт) гэдэг байсан бол орчин үед эрэгтэйчүүд ан агнаж, гэр бүлээ тэжээх шаардлагагүй болсон.
- Жендэрийн ойлголтууд дэвшилтэт, хэвшмэл хоёр янз байж болох юм. Дэвшилтэт үзлүүд нь түүхэнд эрх чөлөөгөө эдлэхэд түлхэц, дэмжлэг болж иржээ. Жишээ нь, 20-30 жилийн өмнө бөх, бокс зөвхөн эрэгтэйчүүдийнх байсан. Ажил мэргэжлийн жендэрийн ялгаа цөөрсөн олон жишээ сурагчид нэрлэж чадна. Жендэрийн ялгаа түүхэн явцад улам цөөрсөөр ирсэн, ирээдүйд бүр ч цөөрөх хандлагатай.
- Багш хичээлээ дүгнэсний дараа хичээлээс олж авсан шинэ мэдлэгийг нь бататгахын тулд Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 4-ийг гэртээ ажиллах буюу дараах 4-н асуултанд хариулж бичих даалгавар өгнө. Ингэхдээ хувийн үзэл бодол бус өнөөдрийн хичээлээс олж авсан мэдлэгтээ тулгуурлах шаардлагатайг сануулна.

АСУУЛТУУД

- *Чи ямар хүйстэй вэ?*
- *Чиний ойлгож байгаагаар ХҮЙС гэж юу вэ?*
- *Чиний бодлоор ЖЕНДЭР гэж юу юм бол?*
- *ХҮЙС, ЖЕНДЭР хоёр хоорондоо ялгаатай болов уу? Хэрэв тийм бол ямар ялгаатай гэж чи бодож байна?*

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.1. “жендэр” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг;

4.1.2. “жендэрийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг;

4.1.3. “жендэрийн хэвшмэл үзэл” гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг;

4.1.4. “жендэрийн ялгаварлан гадуурхалт” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.5. “жендэрийн шууд ялгаварлан гадуурхалт” гэж бусдыг хүйсээр ялгаварлаж адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэсэн, эсхүл хүргэхийг оролдсон үйлдлийг;

4.1.6. “жендэрийн шууд бус ялгаварлан гадуурхалт” гэж хүйсэд хамааралгүй аливаа стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь хүнийг эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэхийг;

4.1.8. “жендэрт суурилсан хүчирхийлэл” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг.

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 4-р зүйл, <http://www.legalinfo.mn/law/details/253?lawid=253>

Хичээлийн сэдэв:

ХҮЧИРХИЙЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Үргэлжлэх хугацаа:

40 минут

Хэрэглэгдэх зүйлс:

Флипчарт цаас

Өнгө, өнгийн фломастер

Хичээл заах аргачлал:

Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх

Ойлголт нэгтгэх

Багшид зориулсан

мэдээлэл:

Хавсралт I-3

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл,

түүнтэй холбоотой зарим

ойлголтууд нэр томъёоны

тодорхойлолт



ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү бүлэг хичээлийн гол зорилго нь сурагчдыг хүчирхийллийн талаарх үндсэн ойлголттой болгохоос гадна хүчирхийллийн төрлүүд, тэдгээрийн ялгаатай байдлын талаар мэдлэгтэй, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хандлагатай болгоход оршино.

Дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

- Сурагчдыг аливаа хүчирхийлэл болон түүний төрлүүдийг тодорхойлж, таньж мэддэг чадвартай болгох
- Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, цаашлаад хүчирхийлэлт харилцаанаас зайлсхийдэг хандлагатай болгох

ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Д/д	ХИЙХ ЗҮЙЛ	ХУГАЦАА	АНХААРАХ ЗҮЙЛ
1.	Хичээлийн танилцуулга	3 мин	"Хүчирхийлэл гэж юу вэ?" сэдэвт хичээлийн зорилго, зорилт, үргэлжлэх хугацаа, заах аргачлал, хичээлээс ямар үр дүнг хүлээж байгаа зэргийг товч танилцуулах бөгөөд оролцооны аргачлалд тулгуурлан хичээлээ явуулна гэдгийг сурагчдад ойлгуулах
2.	Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх дасгал	15 мин	Энэхүү дасгалаар дамжуулан сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, Зургаар дамжуулан "хүчирхийлэл" гэж юу болохыг сурагчдад мэдрүүлэх, Хүчирхийллийн талаарх сурагчдын үндсэн ойлголт, мэдлэгийг таньж мэдэх,
3.	Ойлголт нэгтгэх	15 мин	Багш хүүхдүүдийн зурсан зургуудтай сайтар танилцаж, хүчирхийллийн өөр өөр төрлүүдийн талаар сурагчдад хэлж ойлгуулах, Зурагт илэрхийлэгдээгүй хүчирхийллийн төрлүүдийг нэмж дэлгэрүүлж мэдээлэл өгөх, Ингэхдээ лекцийн арга ашиглан, урьдчилж бэлтгэсэн танилцуулгын тусламжтайгаар хичээлийг заах,
4.	Хичээлийн дүгнэлт	7 мин	Хичээлийн хүрээнд олж авсан шинэ мэдээлэл, мэдлэгээ нэгтгэн дүгнээд хичээлийг дуусгах,

Үйл ажиллагаа 1.

ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Багш сурагчдад хичээлийн сэдэв болон зорилго, зорилтыг товчхон танилцуулж, хичээлийн дараа тэд хүчирхийллийн өөр өөр төрлүүдийг танин мэдэж, хүчирхийлэлт харилцааг ялгаж, зайлсхийдэг хандлагатай болно гэдгийг хэлнэ.

Үйл ажиллагаа 2.**БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ ДАСГАЛ**

Багш сурагчдыг 5 хүний бүрэлдэхүүнтэй жижиг баг болгон хуваана. Ингэхдээ ямар ч төрлийн сонирхолтой арга хэрэглэж болох ба аль болох сурагчдын сонирхлыг татсан, тэднийг идэвхжүүлсэн аргуудаас ашиглахыг хичээгээрэй!

БОЛОМЖИТ ХУВИЛБАР

Тухайлбал, сурагчдын тооноос шалтгаалан 5 багт хуваагдаж болохуйц тооны өөр өөр төрлийн жимсний нэр хэлүүлэх байдлаар багт хувааж болно. Өөрөөр хэлбэл 20 сурагч байвал 4 төрлийн жимсний нэр хэлүүлэх гэх мэт. Эхний сурагч ТООР, дараагийн сурагч НЭРС гэх мэтээр хэлж, ижил жимсний нэр хэлсэн сурагчид нэг баг болно.

Дасгал ажлыг эхлүүлэхийн өмнө Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 1-т сурагчдын анхаарлыг хандуулаарай!

Сурагчдыг багт хуваагдсаны дараа баг тус бүрт флипчарт цаас, фломастер тарааж өгнө. Багийн гишүүдийг флипчарт цаасныхаа дээд буланд “ХҮЧИРХИЙЛЭЛ” гэж бичихийг хүсээд, энэ үгтэй холбоотой, аль болох олон өөр төрлийн үйл явдал, утга бүхий жижиг жижиг зураг зурах даалгавар өгнө. Тухайлбал, нэг ангийн хүүхдүүд бие биедээ дээрэлхүү хандаж буй, аав нь хүүхдээ загнаж буй, гудамжинд танихгүй нэгэнд зодуулж буй гэх мэт хүчирхийлэлт харилцаа, үйлдлийг илэрхийлсэн зураг байж болно.

Багийн гишүүд багшийн өгсөн даалгавраа гүйцэтгэж дууссаны дараа баг тус бүрийг ээлжлэн зурсан зургаа бусаддаа тайлбарлаж өгөхийг хүснэ. Багууд зурсан зургаа ээлжлэн тайлбарласны дараа багш сурагчдыг “ХҮЧИРХИЙЛЭЛ” гэдгийг илэрхийлэх 1-2 үгийг зургаа дүгнэн хэлэхийг хүснэ. Сурагч бүрийн тэгш оролцоог хангах ба сурагчдын хэлсэн үгсийг самбарт жагсаан бичиж дууссаны дараа хичээлийнхээ “Ойлголт нэгтгэх” хэсэгт шилжинэ.

Үйл ажиллагаа 3.**ОЙЛГОЛТ НЭГТГЭХ**

Багш хүүхдүүдийн хүчирхийллийг дүрсэлсэн зураг, илэрхийлсэн үгс зэргээр дамжуулан хүчирхийллийн үндсэн тодорхойлолтыг ойлгомжтой, энгийн үг хэллэгээр тайлбарлана. Түүнчлэн багуудын зурсан зурагт илэрхийлэгдсэн байгаа хүчирхийллийн хэлбэр, төрлүүдийг товч тайлбарлан хэлж, ойлгуулна. Тухайлбал, “Энэхүү зурагт бие махбодийн хүчирхийллийн тухай өгүүлсэн байна” гээд бие махбодийн хүчирхийллийн тодорхойлолт, онцлог зэргийг

хүүхдүүдэд ойлгогдохуйц энгийн ойлгомжтой үгээр тайлбарлахаас гадна өөрийн мэдэх бодит жишээ зэргийг ашиглаж болно.

Хүүхдүүдийн зурсан зурагт илэрхийлэгдээгүй, дүрслэгдээгүй хүчирхийллийн төрөл байж болно. Иймд багш мэдрэмжтэй хандаж, тухайн мэдээллийг нэмэн дэлгэрүүлж, хүүхдүүдэд мэдлэг олгоход анхаарна. Тухайлбал хүүхдүүдэд бэлгийн хүчирхийллийг зургаар илэрхийлэхэд төвөгтэй байхын зэрэгцээ огт зурахгүй байж болно. Энэ тохиолдолд үлдсэн цагт зурагт дүрслээгүй үлдсэн хүчирхийллийн нэг хэлбэр бэлгийн хүчирхийлэл байна гэдгийг онцлоод лекцийн аргаар хүүхдүүдэд ойлгогдохоор тайлбарлаж өгөх хэрэгтэй. Түүнчлэн бэлгийн хүчирхийллийн хохирогчдод илэрдэг түгээмэл шинж нь тэд хэдийгээр өөрсдийгөө хамгаалах үйлдэл хийсэн ч арга зальд автах эсвэл заналхийлүүлж хохирсон байх нь түгээмэл байдаг тул энэ тухай мөн давхар тайлбарлаж өгөөрэй!

Хүчирхийлэл, түүний төрлүүдийн талаарх ойлголт, мэдлэгээ бататгахын тулд Хавсралт 1-д буй нэмэлт мэдээлэлтэй сайтар танилцаж, өөрийн болгоорой! Түүнчлэн хичээлийн “ойлголт нэгтгэх” хэсгийг зөвхөн ярьж тайлбарлах төдий бус урьдчилан ТАНИЛЦУУЛГА бэлтгэж түүнийгээ сурагчдад ярих гэх мэт зэргээр хичээлээ сонирхолтой болгож болно.

Багш тайлбар хийж дууссаныхаа дараа Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 2-ыг ажиллах даалгавар өгнө. Ингэснээр сурагчид багшийн өгсөн мэдлэгийг бататгаж, өөрийн болгох боломжтой юм.

Үйл ажиллагаа 4.

ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

“Хүчирхийлэл гэж юу вэ?” хичээлийг зааснаар дараах үр дүнд хүрнэ.

- *Хүчирхийлэл нь хүчтэй нь хүчгүйгээ дарамтлах буюу эрх мэдлийн тэгш бус, тэнцвэргүй харилцаанаас үүдэлтэй. Өөрийнхөө хүсч буйг бусдаар хийлгэх хүслээс улбаатай. Өөрөөр хэлбэл, хүчирхийлэл гэдгийг маш энгийнээр эрх мэдэлтэй хэн нэгэн өөрийн зорилгод хүрэхийн тулд насаар бага, сул дорой, хүч дутмаг эсвэл эрх мэдэл багатай хэн нэгнийг албадах, тэдэнд хүч хэрэглэж байгаа үйлдлийг ойлгож болно. Тухайлбал, гэр бүлийн хэн нэгэн давуу эрх мэдэлтэй насанд хүрсэн гишүүн (эрэгтэй, эмэгтэй хэн ч байж болно) хүүхдийг өөрийн хүссэнээрээ байлгах, хүссэн зүйлээ хийлгэхийн тулд тэднийг хүсэхгүй байхад нь албадах, улмаар хүч хэрэглэх нь хүүхдийн хүслийн эсрэг үйлдэл буюу хүүхдийн эсрэг хүчирхийлэл болно.*
- *Хэдий тийм боловч эрх мэдэлтэй хүн бүр хүчирхийлэгч биш юм. Өөрийн зорилгодоо хүрэхийн тулд ямар аргыг ашиглаж байна гэдгээс шалтгаалан хүчирхийлэл үйлдэж байна*

уу, үгүй юу гэдгийг тодорхойлох боломжтой.

- Хүчирхийллийн хэлбэрийг танин мэддэг байх нь түүнээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн хэн нэгэнд тусламжийн гарцыг хэлж өгөх ач холбогдолтой. Хүчирхийллийн золиос болсон ихэнх хүмүүс өөрсдийгөө хүчирхийлэлт харилцаа, орчинд байгаагаа хүлээн зөвшөөрөхгүй удаан хугацааг өнгөрөөсөн байдаг. Энэ нь ихэнхдээ тэдний хүчирхийллийг ойлгох ойлголт, танин мэдэх байдал, ялгах чадвар, хэлбэрийн талаар мэдэхгүйтэй холбоотой байдаг.

Танхимд олж авсан мэдлэг, мэдээллийг нь бататгах үүднээс Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 3-ыг гэртээ ажиллах даалгавар өгнө.

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ОЙЛГОЛТУУД

“Хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэдгийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Тодорхойлолт 1

Хэн нэгэн этгээд өөрийн хүч, эрх мэдэл, давуу байдлаа ашиглан, хүүхдийн халдашгүй дархан байх эрх, эрх чөлөөг зөрчсөн, гэм хор учруулсан, эсвэл учруулахаар завдсан, түүнийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл, эс үйлдэхгүйг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэнэ.

Тодорхойлолт 2

Өөрийн асрамжинд байгаа 18-аас доош насны хүүхдэд сэтгэл санааны болон оюуны хохирол учруулах, үл хайхрах, хоол хүнсээр гачигдуулах, эрүүл мэнд, амь насанд нь хор учруулахыг хүчирхийлэх гэнэ.

Тодорхойлолт 3

Хүүхдийн эсрэг дарамт хүчирхийлэл гэж хүүхдийг өөрийн эрхтэйгээ байлгах, давамгайл байдал тогтоох, шийтгэх зорилгоор хэн нэгэн этгээд хүч, эрх мэдэл, давуу талаа ашиглан хүүхдийн халдашгүй дархан байх эрх, эрх чөлөөг зөрчсөн, гэм хор учруулсан, эсвэл учруулахаар завдсан, энэ байдлыг мэдсээр байж хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг үйлдэл, хор холбогдлын төсөөтэй шинжээр нь дараах 4-н хэлбэрт хуваадаг. Үүнд:

<p>Бие махбодийн хүчирхийлэл</p>	<p>Хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах зорилгоор хэн нэгэн этгээд хүч хэрэглэн хүүхдийн биед ямар нэгэн хэмжээгээр халдах, эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг хэлнэ.</p>
<p>Сэтгэл санааны хүчирхийлэл</p>	<p>Хүүхдийг өөрийн эрхшээлдээ байлгах зорилгоор хэн нэгэн этгээд өөрийн давуу байдлаа ашиглан үг хэл, үйл хөдлөлөөрөө сэтгэл санааны дарамтанд оруулсныг, эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг хэлнэ.</p>
<p>Бэлгийн хүчирхийлэл</p> <ul style="list-style-type: none"> • Хүрэлцэх • Үл хүрэлцэх 	<p>Хүүхдийн халдашгүй дархан байдал, бэлгийн эрх чөлөөг зөрчсөн, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн болон садар самууны шинжтэй бусад үйлдэлд уруу татсан, шаардсан, эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг хэлнэ.</p>
<p>Хүүхдийг үл хайхрах</p>	<p>Хэн нэгэн этгээд хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, эрүүл мэнд, хөгжил боловсрол, хайр халамж, аюулгүй байдлыг нь хангах зэрэг суурь хэрэгцээг нь гачигдуулсны улмаас хүүхдэд гэм хор учруулсан болон учруулахаар завдсан, эсхүл энэхүү нөхцөл байдлыг мэдсээр байж хүүхдийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй зэргийг ойлгоно. Энэ нь сэтгэл санааны, бие махбодийн, эрүүл мэндийн, боловсролын хувьд үл хайхрах, аюулгүй байдлыг хангахгүй байх зэргээр санаатай болон санамсаргүй байдлаар илэрнэ.</p>

Хичээлийн сэдэв:

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ ГЭЖ НОУ ВЭ?

Үргэлжлэх хугацаа:

40 минут

Хэрэглэгдэх зүйлс:

Флипчарт цаас

Самбарын маркер

Хичээл заах аргачлал:

“Жендэрийн хайрцаг” дасгал

ажиллах

Бодит жишээн дээр ажиллах



ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Хичээлийн гол зорилго нь өмнө үзсэн жендэр болон хүчирхийлэл сэдэвт хичээлээр олж авсан мэдлэгт тулгуурлан жендэрт суурилсан хүчирхийллийн ялгаатай байдал, онцлогийг танин мэдэхэд оршино.

Хичээлийн зорилтууд:

- Жендэрт суурилсан хүчирхийллийн тодорхойлолтод суралцах\
- Хүчирхийлэл яагаад жендэрээс улбаатай үйлдэгддэг болох шалтгааныг таниулах
- Хүчирхийлэл нь зөвхөн хүйс хооронд үйлдэгддэг гэмт хэрэг биш гэдгийг ойлгуулах

ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Д/д	ХИЙХ ЗҮЙЛ	ХУГАЦАА	АНХААРАХ ЗҮЙЛ
1.	Хичээлийн танилцуулга	5 мин	<p>“Жендэрт суурилсан хүчирхийлэл гэж юу вэ?” сэдэвт хичээлийн зорилго, зорилт, үргэлжлэх хугацаа, заах аргачлалыг товч танилцуулах бөгөөд оролцооны аргачлалд тулгуурлан хичээлээ явуулна гэдгийг сурагчдад ойлгуулна.</p> <p>ЖСХ сэдэвт хичээлийг эхлүүлэхдээ өмнө үзсэн жендэр ба хүчирхийлэл хэмээх хичээлээс олж авсан үндсэн мэдлэгийг бататгана.</p>
2.	“Жендэрийн хайрцаг” дасгал ажиллах	20 мин	<p>“Жендэрийн хайрцаг” дасгал ажиллуулах бөгөөд уг дасгалын ачаар багш сурагчдынхаа “хүйсийн талаарх хадлага”-ыг таньж мэдэх боломжтой болно. Өөрөөр хэлбэл сурагчид нь жендэрийн уламжлалт хандлагатай байна уу, эсхүл дэвшилтэт хандлагатай байна уу гэдгийг урьдаас мэдэх боломжтой болно гэсэн үг. Ингэснээр багш хичээлээ хэрхэн зааж, ямар үр дүнд хүрэх талаарх төсөөллийг бий болгоно.</p>
3.	Ойлголт нэгтгэх	10 мин	<p>Өгөгдсөн асуултуудын дагуу хэлэлцүүлэг өрнүүлэх бөгөөд сурагчдын тэгш, бодит оролцоог хангаж ажиллахыг хичээнэ.</p> <p>Энэхүү хичээл нь бүхий л хичээлийн турш маш чухал учир өөрийн хувь хүний үзэл бодол, баримтлалд автахгүйгээр, жендэрийн дэвшилтэт үзэл санаанд тулгуурлан хичээлээ заана</p>
4.	Хичээлийн дүгнэлт	5 мин	<p>Хичээлийн хүрээнд олж авсан шинэ мэдээлэл, мэдлэгээ нэгтгэн дүгнээд хичээлээ дуусгана.</p>

Үйл ажиллагаа 1.

ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Жендэрт суурилсан хүчирхийлэл гэж юу вэ хэмээх хичээлийн зорилго, зорилтыг товч танилцуулаад сургалтын дараа ямар шинэ мэдлэг, мэдээлэлтэй болсон байх тухай урьдчилсан

төсөөллийг сурагчдад би болгоод хичээлийг эхлүүлнэ.

Өмнө үзсэн ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЭР, ХҮЧИРХИЙЛЭЛ гэсэн хичээлүүдээс олж авсан мэдлэгээ богино хугацаанд эргэн санах зорилгоор оролцогчдоос дараах асуултуудыг нээлттэй асууна.

- Жендэр гэж юу вэ?
- Хүчирхийлэл гэж юу вэ?

Үйл ажиллагаа 2.

ЖЕНДЭРИЙН ХАЙРЦАГ ДАСГАЛ АЖИЛАХ

Багш сурагчдыг охид, хөвгүүдээр нь ялган танхимын 2 хэсэгт хуваан суулгаад “Жендэрийн хайрцаг” хэмээх дасгал ажиллах тухай хэлнэ. Түүнчлэн Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 1-т хүүхдүүдийн анхаарлыг хандуулна. Багуудад флипчарт цаас болон маркер тарааж өгнө.

Хөвгүүдийн баг эрэгтэй хүүхэд зурах бол харин охидын баг эмэгтэй хүүхэд зурна гэдгийг хэлээд зурсан хүүхэддээ нэр өгнө гэдгийг хэлнэ. Ингээд нийгэм, олон нийт, хүрээлэн буй хүмүүс, гэр бүлийнхэн, найзууд нь тухайн хүүхдийг ямар байгаасай гэж хүсдэг болохыг зурсан зургаа тойруулаад бичихийг хүснэ. Жишээлбэл: охидыг эелдэг даруу, дөлгөөн, гэрийн ажилд сайн, онц сурдаг гэх мэт

Багууд өөрсдийн ажлаа бусаддаа танилцуулсны дараа багш дараах асуултуудыг дэс дараалан багийн гишүүдээс асууна.

- *Эдгээрээс өөр байх тохиолдол байдаг уу? Жишээлбэл...?*
- *Хэрэв тийм бол олон нийт хэрхэн ханддаг вэ? Жишээлбэл...?*
- *Та нарт хуваалцах бодит жишээ байна уу?*

Багш сурагчдаас хариулт авсны дараа “Жендэрийн хайрцаг”-ийн талаар тайлбар хийнэ. Хүүхдүүдийн зурсан зураг болон охид, хөвгүүдийг нийгэм ямар байгаасай гэж хүсдэг талаарх тэдний бодол нь “жендэрийн хайрцаг” юм гэдгийг тайлбарлана. Өөрөөр хэлбэл нийгэм хүмүүсийг хүйсээс нь хамаарч ямар байлгахыг хүсч байгаа нь “жендэрийн хайрцаг” хэмээн ойлгогдоно. Тухайлбал, охидыг онц сурдаг, даруу төлөв зантай, хөвгүүдийг зоригтой, баатарлаг, хүч чадалтай байх шаардлагатай мэтээр хандах нийгмийн хандлага нь охид, хөвгүүдийг өөрөөрөө байх боломжгүй болгож “хайрцаглаж” байдаг.

Цаашлаад нийгмээс өгсөн энэхүү хүлээлт, шаардлагад нийцэхгүй өөрөөр хэлбэл “хайрцаг”-аас гадна байх тохиолдолд ямар үр дагавар учирдаг талаар үргэлжлүүлэн

ярилцана. Улмаар нийгмийн хүлээлтээс өөр байх тохиолдолд хүчирхийлэл дарамтад өртдөг болохыг тайлбарлаад “жендэрт суурилсан хүчирхийлэл”-ийн тодорхойлолтыг оролцогчдод ойлгомжтой, энгийн үг хэлээр, бодит жишээнд тулгуурлан тайлбарлана. Эцэст нь сурагчдыг эргэн багтаа нэгдээд дээрх “жендэрийн хайрцаг”-аас өөр, гадуур байсан, өөрөөр хэлбэл нийгмийн хүлээлтээс ангид байсан 2 бодит жишээ олох даалгавар өгнө.

Хуулийн тодорхойлолт

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ

4.1.8 “жендэрт суурилсан хүчирхийлэл” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг;

Үйл ажиллагаа 3.

БОДИТ ЖИШЭЭН ДЭЭР АЖИЛЛАХ ДАСГАЛ

Сурагчдыг 3 багт хуваан доорх жендэрт суурилсан хүчирхийллийн бодит жишээ өгнө. Тухайн бодит жишээнд үндэслэн дараах асуултад багаараа хариулж, Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 2 хэсэгт тэмдэглэл хөтлөх даалгавар өгнө

ЖСХ мөн үү, тийм бол яагаад үгүй бол яагаад?

Хүчирхийллийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгч нь хэн байсан,

Хохирогч нийгмээс оноосон дүрээс өөр байсан эсэх,

Хүчирхийлэлд өртөх болсон шалтгаан нь юу байсан?

Бодит жишээ 1

Ц 15 настай, эрэгтэй. Тэрээр багадаа маш хүндээр өвдөж байсан учраас сургуулиасаа чөлөө авч, удаан хугацаанд гэртээ байсан. Саяхнаас хичээлдээ явж эхэлсэн. Тэр бусад хөвгүүдээс намхан, туранхай, жижиг биетэй. Биеийн эрүүл мэндийн байдлаасаа шалтгаалаад спортоор хичээллэх боломжгүй бөгөөд биеийн тамирын хичээлээс чөлөөлөгдсөн. Ангийнхан нь түүнийг “сульдаа”, “тэнэг”, “ижил хүйстэн шиг”, “охин шиг” гэх мэтээр шоолж, гоочилдог. Мөн ангийн хөвгүүд нь байнга мөнгө нэхэж дарамталдаг төдийгүй өгөхгүй бол зоддог.

Бодит жишээ 2

Н 16 настай, эмэгтэй. Үеийнхээ охидуудаас илүү биерхүү, бүдүүн хоолойтой, чөлөөт бөхөөр хичээллэдэг. Энэ спортдоо маш их дуртай бөгөөд амжилттай сайн тамирчин. Ихэнх цагаа зааланд, бэлтгэл хийж өнгөрөөдөг. Түүнийг ангийхан болон багш нар нь эмэгтэй байхыг шаарддаг бөгөөд үеийн охид нь түүнтэй найзлахаас татгалздаг. Учир нь түүний байгаа байдал яг л эрэгтэй хүүхэд шиг, охидуудын сонирхдог зүйлсийг нэгийг нь ч сонирхдоггүй гэдэг.

Бодит жишээ 3

Манай ах намайг байнга зоддог. Урьд нь манай аав архи уудаг байхдаа ээж, ах, бид нарыг дандаа зоддог байсан. Харин 2 жилийн өмнөөс архи уухаа болиод бид нарыг зодохоо ч бас больсон. Гэтэл ах намайг зоддог болж эхэлсэн. Гэр цэвэрлэсэнгүй, хичээлээ хийсэнгүй, эрэгтэй хүүхэдтэй уулзлаа гээд шалтаг л гарвал миний толгой руу цохиж, гэдэс рүү өшиглөдөг...

Багууд хийсэн дүн шинжилгээгээ бусаддаа танилцуулна. Бусад багийн гишүүдийг асуулт асуух, үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангана.

Үйл ажиллагаа 4.

ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

Нийгмээс өгсөн дүр, хэвшмэл хандлагаас өөр эсвэл өвөрмөц байдлаас үүдэн бусдыг доромжлох, нэр хоч өгөх, хүч хэрэглэх нь жендэрт суурилсан хүчирхийлэл юм.

Мөн эмэгтэй эсвэл эрэгтэй болж төрсөнөөсөө шалтгаалан хүний эрхийн зөрчилд өртөж байна. Жишээлбэл “сайн эхнэрийг сард нэг удаа зод” гэх мэтчилэн эр нөхөр бол эхнэрээ зодох ёстой гэсэн буруу ойлголт, хандлага хүчирхийлэл үйлдэгчдийг төрүүлж байна. Ганцхан эрэгтэй хүн эрх мэдлийн давуу байдал, хүч чадлаа ашиглан эмэгтэй хүнийг хүчирхийлэх биш, хүйс хооронд ч бие биенээ хүчирхийлэх, доромжлох гэх мэт маш өргөн ойлголтой.

Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч нь зөвхөн охид, эмэгтэйчүүд биш юм. Нийгмийн хүлээлттэй үл нийцсэн хөвгүүд, эрэгтэйчүүд ч ЖСХ-ийн хохирогч болдог. Тухайлбал, дэлхийн олон улс оронд өсвөр насны эрэгтэй хүүхдүүд хүчирхийллийн золиос буюу хэрэг төвөгт орооцолдох, гэмт бүлэглэлийн гишүүн болох нь элбэг байдаг бөгөөд энэ нь эр хүн гэдгээ үеийнхэндээ харуулах, нотлох гэсэн сэдлээс үүдэлтэй буруу замаар орох нь элбэг байдгийг тогтоожээ.

Энэ удаагийн хичээлийн дүгнэлтээ сурагчдын оролцоотойгоор хийсний дараа Сурагчдад зориулсан гарын авлага дээрх **Дасгал 3**-ыг бие даан гэртээ ажиллаж, өгөгдсөн асуултуудад хариулах даалгавар өгнө.

Хичээлийн сэдэв:

НАЙЗДАА ТУСЛАХ БОЛОМЖ НАДАД БИЙ ЮУ?

Үргэлжлэх хугацаа:

40 минут

Хэрэглэгдэх зүйлс:

Сурагчдыг тойрог
болгон суулгах саруул
танхим

Хичээл заах

аргачлал:

Дүрийн тоглолт
Бүлгийн ажил

Багшид зориулсан

мэдээлэл:

Хавсралт 1-5

ЖСХ-ийн улмаас бие

махбодид учрах үр

дагавар



МОНДУЛЬ 5

ЖЕНДЭРТ СҮҮРИЛСАН ХҮЧИРХИЙНЭМЛИЙН ҮР ДАГАВАР

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Энэ удаагийн хичээлийн гол онцлог нь ЖСХ-ийн улмаас бие махбодид ямар төрлийн гэмтэл, бэртэл учирч болох эрсдэлтэйг сурагчдад ойлгуулах явдал юм.

Хичээлийн зорилтууд:

- ЖСХ-ийн үр дагаврыг ойлгож ухаарах,
- ЖСХ-ийн бие махбодид учирч болох үр дагаврын талаар анхан шатны ойлголттой болох,
- Найз нөхөд, ойр дотны хүмүүс нь хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй гэмтэл авсан тохиолдолд хэн нэгэнд заавал мэдээлэх шаардлагатай талаар ойлголт өгөх,

ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Д/д	ХИЙХ ЗҮЙЛ	ХУГАЦАА	АНХААРАХ ЗҮЙЛ
1.	Хичээлийн танилцуулга	5 мин	<i>Хичээлийн зорилго, зорилт, үргэлжлэх хугацаа, заах аргачлалыг товч танилцуулах бөгөөд оролцооны аргачлалд тулгуурлан хичээлээ явуулна гэдгийг сурагчдад ойлгуулах,</i>
2.	Дүрд тоглох	20 мин	<i>Дүрд тоглох дасгал ажиллуулахдаа цагийн хуваарилалтанд анхааралтай хандах, ЖСХ-ийн улмаас бие махбодид учирч болох эрсдлийг хөнгөн хэлбэрээс хүнд хэлбэр хүртэл харуулсан жишээ өгөгдсөн байгаад анхааралтай хандах, ЖСХ-ийн улмаас зөвхөн бие махбодид ур дагавар учирдаггүй болохыг анхааруулж хэлэх бөгөөд дараа дараагийн ангид үзэх хичээлийн хүрээнд бусад төрлийн хүчирхийллийн үр дагаваруудаас суралцана гэдгийг ойлгуулж хэлэх,</i>
3.	Хэлэлцүүлэг өрнүүлэх	10 мин	<i>Бэлдсэн асуултуудын дагуу багуудын дунд хэлэлцүүлэг, ярилцлага өрнүүлнэ.</i>
4.	Хичээлийн дүгнэлт	5 мин	<i>Хичээлийн хүрээнд олж авсан шинэ мэдээлэл, мэдлэгээ нэгтгэн дүгнээд хичээлээ дуусгана.</i>

Үйл ажиллагаа 1.

ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Багш сурагчдад энэ удаагийн хичээлийн сэдэв болон зорилго, зорилтыг товчхон танилцуулахаас гадна хичээлийн төгсгөлд сурагчид ямар шинэ ойлголт, мэдээлэлтэй болсон байх талаарх урьдчилсан төсөөллийг бий болгоно. Түүнчлэн “хүчирхийлэл” сэдэвт хичээлээр хүчирхийллийн олон төрлийн талаар үзсэнийг хүүхдүүддээ дахин сануулаад бие махбодийн хүчирхийллийн улмаас үүсэх үр дагаврын талаар онцгойлон судална гэдгийг тайлбарласны дараа “дүрийн тоглолт” хэрхэн хийх зааварчилгааг танилцуулна.

Үйл ажиллагаа 2.**ДҮРД ТОГЛОХ**

Сурагчдыг 5 гишүүнэс бүрдсэн баг болгон хуваана. Баг тус бүрт хөнгөн хэлбэрээс хүнд хэлбэрийн бие махбодийн гэмтэл авсан 4 өөр төрлийн “жишээ” тарааж өгнө. Уг жишээг багийн бүх гишүүд уншиж танилцаад, 3-5 минутын богино хэмжээний жүжигчилсэн тоглолт бэлтгэж бусаддаа үзүүлж, сонирхуулах даалгавар өгнө. Өгөгдөл бүрт гарч буй гол дүрийн хүүхдүүдийн нэрийг ангийн хүүхдүүдийн нэрээс өөрөөр нэрлэж болохыг анхаарна уу.

Доорх өгөгдлүүдийг Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 1-ээс харах боломжтойг хүүхдүүдэд хэлнэ.

Өгөгдөл 1

Ц, З, М гурав ангийнхаа 3 хөвгүүний хамт хичээлийн дараа анги цэвэрлэхээр хуваарилагджээ. Ангийн багш нь охид, хөвгүүд гэлгүйгээр цэвэрлэгээний бүх ажлуудыг тэнцүү хувааж хийхийг шаардаад өөр ангид хичээл заахаар явжээ. Ангийн багш байхгүйг далимдуулан хөвгүүд үүрэгт ажлаа хийлгүйгээр ангид хөзөр тоглож эхэлсэн байна. М тэднийг цэвэрлэгээгээ хийхийг шаардтал, “охид л цэвэрлэгээ хийх ёстой биздээ?” гээд огт анхаарал хандуулаагүй байна. Гэтэл Ц “Та нарыг цэвэрлэгээгээ хийхгүй байна гэж багшид очиж хэллээ шүү!” гэтэл ангийнх нь нэг хөвгүүн “Сүртэй юм бэ чи! Хийх ёстой ажлаа хийж чадахгүй юундаа хов зөөх гээд байгаа юм бэ?” гээд гартаа тааралдсан нэг зүйлийг шидтэл Ц-ийн духанд онож, толгойг нь хагалжээ. Ц эмнэлгийн тусламж авах шаардлагатай болсон байна.

Өгөгдөл 2

А бол сургуулийнхаа хамгийн царайлаг бас гоё биетэй, даруухан охин юм. Сургуулийн бүх л хөвгүүд түүнийг шохоорхоно. Гэвч А зөвхөн хичээлдээ л анхаарч энэ бүгдийг тооддоггүй байв. Харин дээд ангийн охид А-д тийм ч тааламжтай биш ханддагаас гадна сургуулийн коридорт зөрөхдөө мөрлөх, дэгээдэх, үг хэлээр доромжлох зэргээр ханддаг байлаа. Нэг өдөр сургуулийн коридорт энэ үйлдэл давтагдаж, А-г явж байхад нь дэгээдэж унагаасан бөгөөд тэрээр унаснаасаа болоод өвдгөө гэмтээсэн. А үүнээс болж хэд хоног хичээлдээ явах боломжгүй болсноос гадна хичээлдээ муудаж, дуугүй зожиг болж өөрчлөгдөж эхэлжээ. Найзыгаа өөрчлөгдөж байгааг сайн найз Ц хараад түүнд урмын үг хэлж тайвшруулахыг хичээсэн ч үр дүнгүй байв. Эцэст нь энэ

талаар сургуулийнхаа нийгмийн ажилтанд хэлсэн нь зөв алхам болж чадсан юм.

Өгөгдөл 3

С-ийн хувьд 3 бол энэ сургуульд шилжиж ирээд найзалж байгаа хамгийн сайн найз нь юм. Амралтын 2 өдөр дуусч хичээлдээ ирэхэд Заяагийн бугуй хөхөрсөн байхыг С хараад яасныг асуухад гэрээсээ гарахдаа унаж ийм болгосон хэмээн хариулжээ. Энэ явдлаас нэлээд хэд хоногийн дараа 3-ийн гар дахиад л хөхөрсөн байв. Үүнийг С хараад яагаад ийм болсныг асуухад 3 урьдын адил хариуллаа. Гэвч үүнд С итгэсэнгүй дахин дахин асуухад 3-ийн аав хүнтэй суусан бөгөөд хойд ээж нь түүнийг гэрийн ажил хийсэнгүй хэмээн зоддог байсныг уйлан уйлан ярьжээ. С найзыгаа тайвшруулж аргадаад энэ хэргийг дуугүй өнгөрч болохгүй гээд түүнд тусалж чадах хүнд хэлэхээр ярилцаж тогтлоо. Маргааш нь 2 найз хичээл тарсны дараа ангийн багшдаа болсон явдлыг яриу. Ингэснээр ангийн багш сургуулийн нийгмийн ажилтан нар хороо, цагдаа гээд хөл хүрэх газраараа явж энэ хэргийг эерэгээр шийдэж чадсан юм.

Өгөгдөл 4

Б 9-р ангиа сумандаа төгсөж 10-р ангиасаа эхлэн аймгийн төвд суралцахаар болов. Учир нь суманд 9 жилээс дээш анги байдаггүй байв. Болдын гэр бүлийнхэн аймагт таних хүнгүй учир дотуур байранд байхаар боллоо. 9 сарын 1-ээс эхлэн Б-д болон бусад хөдөөнөөс ирсэн хөвгүүдэд нэг хэцүү асуудал гарсан нь дээд ангийн хөвгүүд тэднийг дээрлэх, юмыг нь булаан авах заримдаа зодох тохиолдол байдаг байв. Энэ бүгдийг ангийн охидууд мэдээж мэддэг байснаас гадна байдаг л зүйл гэж ойлгодог байсан юм. Гэхдээ энэ нь Б-д маш хүндээр тусч түүний сурлага муудаж, ойр ойрхон хичээлээ таслан хөдөө байдаг гэрлүүгээ явдаг болов. Б-той нэг ширээнд суудаг охин түүнд хэцүү байгааг ойлгосон учраас энэ бүгдийг Б-ын ар гэрийнхэнд хэлснээр эцэг эх нь сургуулийн захиргаанд гомдол гаргасан байна. Ингэснээр сургуулийн захиргаа энэ асуудалд арга хэмжээ авч дахин ийм явдал гарсангүй.

Үйл ажиллагаа 3.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛЭХ

Багуудыг жүжигчилсэн тоглолтоо үзүүлж дууссаны дараа дахин бүлгээр ажиллуулах ба дасгал ажлын номны Дасгал 2-ыг ажиллуулна. Ингэхдээ жүжигчилсэн тоглолтоор үзүүлсэн түүхтэй холбоотой доорх асуултуудыг багуудад санамсаргүй байдлаар хуваарилж өгнө. Ингэснээр

багууд өөрсдийн үзүүлсэн түүхийн тухай биш өөр багийн үзүүлсэн түүхийн талаар ярих юм. Багш баг тус бүр өөр багийн түүхийн талаар ярилцах ёстойг анхаарч ажиллана. Багш багуудад флипчарт цаас, маркер зэргийг тарааж өгнө. Багийн гишүүд асуултын дагуу хоорондоо ярилцаж, тэмдэглэл хөтлөнө. Эцэст нь бусад багуудад танилцуулна. Доорх асуултуудын дагуу хэлэлцүүлгээ өрнүүлнэ.

Өгөгдөл 1-ийн асуултууд

- Охид, хөвгүүдэд хандах ангийн багшийн хандлага ямар байсан бэ?
- М, Ц 2 ямар арга хэмжээ авсан бэ?
- Ц-д ямар гэмтэл учирсан бэ?
- Зөвхөн охид л цэвэрлэгээний ажил хийх ёстой гэсэн хандлага нь жендэрт суурилсан хүчирхийлэл мөн үү? Хэрэв тийм бол яагаад? Үгүй бол яагаад?
- Олон нийтийн энэхүү хандлагаас үүдээд охидод ямар нэгэн сөрөг үр дагавар учирч болох уу?

Өгөгдөл 2-ын асуултууд

- А-д юу тохиолдсон бэ?
- А-д тохиолдож байгаа зүйл жендэрт суурилсан хүчирхийлэл мөн үү?
- Уг явдлаас болоод А хэрхэн өөрчлөгдсөн бэ?
- Сургууль дээрх таагүй зүйлсийг эцэг эхтэйгээ ярилцах хэрэгтэй юу?
- Ц найзынхаа төлөө ямар үйлдэл хийсэн бэ?

Өгөгдөл 4-ийн асуултууд

- Б-д тохиолдож байгаа зүйл энгийн, байдаг л зүйл мөн үү?
- Б өөрт нь тохиолдож байгаа зүйлийн талаар хэн нэгэнд хэлэх ёстой байсан уу?
- Б-д тохиолдож буй зүйл жендэрт суурилсан хүчирхийлэл мөн үү?
- Б-ын ширээний найз болсон явдлын талаар түүний гэр бүлхэнд хэлсэн нь зөв үйлдэл байсан уу?
- Хэрвээ энэ үйлдэл зөв байсан бол ямар үр дүн авч ирсэн бэ?

Үйл ажиллагаа 4.

ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

Жүжигчилсэн тоглолт болон бүлгийн ажлын дүнд дараах дүгнэлтийг оролцогчидтой хамтран хийж болно.

- *ЖСХ-ийн улмаас үүсэх үр дагавар янз бүр байдаг.*
- *ЖСХ нь хүний биед үл мэдэгдэм гэмтэл учруулж болох хэдий ч хүний сэтгэл санаа, өөртөө итгэх итгэл, эрхэм чанар, биеэ авч явах байдалд сөрөг үр дагавар авч ирдэг.*
- *Хэн ч хүчирхийлэлд өртөхийг хүсдэггүй. Хүчирхийлэл нь хүний нэр төр, эрхэм чанартай салшгүй холбоотой байдаг учраас хүчирхийлэлд өртсөн хүмүүс өөрсдийгөө тэр бүр илчилдэггүй. Иймд ойр дотны хэн нэгэн хүн хүчирхийлэлд өртсөн эсвэл өртсөн байж болзошгүй гэмтэл биедээ авсан тохиолдолд анзаараагүй мэт өнгөрч болохгүй. Тэр тусмаа бага насны хүүхдэд заавал туслах ёстой бөгөөд энэ нь иргэн бүрийн үүрэг гэдгийг ухамсарлах ёстой. Гадаад улс оронд бага насны хүүхдэд туслаагүйгээс хүлээлгэх хариуцлагыг мэргэжилтнүүдэд зүйлчилж оруулсан байдаг.*
- *Хүчирхийллийн хажуугаар дуугуй өнгөрч болохгүй. Хэрэв өөрөө туслах боломжгүй гэж үзэж байгаа үед энэ асуудлыг шийдэж чадах хэн нэгэн насанд хүрсэн хүнд мэдээлэх хэрэгтэй.*
- *ЖСХ-ийн улмаас сэтгэл санаанд хохирол учрахаас гадна биеийн эрүүл мэнд, цаашлаад амь насанд ч аюултай үр дагаварыг авчирч байдаг.*

ЖСХ-ИЙН УЛМААС БИЕ МАХБОДИД УЧРАХ ҮР ДАГАВАР

ЖСХ хүний эрүүл мэндэд асар их хохирол авч ирдэг.

- Биеийн эрүүл мэнд, гэмтэл бэртэл учруулдаг
- Сэтгэл зүйн таагүй байдал
- Нөхөн үржихүйн эрүүл мэнд
- Эрсдэлтэй зан үйл буюу донтолт, бэлгийн олон хавьтагчтай болох гэх мэт

ЖСХ нь хүүхдийн бие мабод, эрүүл мэндэд хор хохиролтой.

- Хүмүүжлийн гажуудал, хэрэгт холбогдох эрсдэл өндөр болно.
- Уур, уцаар, тэвчээргүйтэл зэрэг сэтгэл, сэтгэлийн тэнхээгүй байдал
- Хөгжихөд садаа болно: бусдад үл итгэл, нийгмийн чадвар сул
- Бие махбодийн болон эрүүл мэндийн үр дагаврууд: Дутуу жинтэй төрөх психосоматик шинж тэмдэг
- Оюуны хоцрогдол буюу сурлагадаа муудах эрсдэлтэй.

ЖСХ нь эмэгтэй хүний ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдлийг нэмэгдүүлнэ

- Бэлгийн хүчирхийллийн замаар шууд эрсдэлд орно.
- Бэлгийн харьцааг бүрэн хянаж чадахгүй болно.
- Бэлгэвчийг хэрэглүүлэх тал дээр нөлөөлөх чадвар бага болно.

Хичээлийн сэдэв:

БИ ХЭНД ИТГЭЖ
БОЛОХ ВЭ?

Үргэлжлэх хугацаа:

40 минут

Хэрэглэгдэх зүйлс:

Бичгийн цаас

Үзэг

Балын харандаа

Хичээл заах аргачлал:

Эргэцүүлэл бий болгох

дасгал ажил

Асуултанд хариулах

ганцаарчилсан дасгал

Асуулт, хариулт



МОНДУУЛЫН 6

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙНЭМД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

“Би хэнд итгэж болох вэ?” хичээлийн гол зорилго нь сурагчид өөрийн хамгийн их итгэл хүлээлгэсэн насанд хүрсэн хүн хэн байж болохыг тодорхойлж сурахаас гадна ЖСХ-д өртсөн тохиолдолд хамгийн анх хэнд мэдээлэх насанд хүрсэн хүмүүсийн нэрсийн жагсаалттай болох явдал юм.

ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Д/д	ХИЙХ ЗҮЙЛ	ХУГАЦАА	АНХААРАХ ЗҮЙЛ
1.	Хичээлийн танилцуулга	5 мин	<i>“Би хэнд итгэж болох вэ?” сэдэвт хичээлийн зорилго, зорилт, үргэлжлэх хугацаа, заах аргачлалыг товч танилцуулах бөгөөд ганцаарчилсан дасгал ажил болон нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх замаар хичээлээ явуулна гэдгийг сурагчдад мэдээлэх,</i>
2.	Дасгал ажил	15 мин	<i>ЖСХ-ийн хохирогчийн талаарх бодит түүх хуваалцах замаар сурагчдад эргэцүүлэл бий болгох</i>
3.	Ганцаарчилсан дасгал ажил	10 мин	<i>Энэхүү дасгал ажлыг ажиллуулснаар хүүхдүүд гол төлөв хэнд итгэдэг, хэнд итгэл хүлээлгэдэг болох талаар дүр зурагтай болох, Хамгийн чухал нь насанд хүрсэн бүх хүмүүст итгэх боломжгүй хэдий ч чин сэтгэлээсээ туслах, дэмжих чадвартай, итгэж болох насанд хүрсэн хүн байдаг гэдэг санааг хүүхдүүдэд өгөх,</i>
4.	Хичээлийн дүгнэлт	10 мин	<i>Хичээлийн хүрээнд олж авсан шинэ мэдээлэл, мэдлэгээ нэгтгэн дүгнээд хичээлээ дуусгана. Сурагч бүр итгэл хүлээлгэж болох насанд хүрсэн хүний нэрсийн жагсаалттай болсон байна.</i>

Үйл ажиллагаа 1.

ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Энэ удаагийн хичээлийн хүрээнд хүүхдүүдэд тэдний эргэн тойронд байдаг, өдөр тутамд харьцдаг, тойрон хүрээлж байдаг насанд хүрсэн хүмүүсээс хамгийн итгэж, найдаж болохоор хүмүүс гэж хэнийг хэлэх, хэн байж болох, тэднийг хэрхэн таних тухай ойлголттой болно гэдгийг тайлбарлана. Түүнчлэн хичээлийн дараа бүх хүүхдүүд итгэж болох насанд хүрсэн хүмүүсийн нэрсийн жагсаалттай болно гэдэг мэдээлэл өгөх хэрэгтэй.

Үйл ажиллагаа 2.

Н ОХИНД ЮУ ТОХИОЛДСОН БЭ? ДАСГАЛ АЖИЛ

Сурагчдаас сайн дураараа 1 хүүхэд гарч ирэхийг хүсэх ба “Н охинд тохиолдсон

явдал"-ыг бусад найзууддаа тод чанга дуугаар, сонсогдохуйц уншиж өгөхийг хүснэ. Түүнчлэн Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 1-ийг нээх зааварчилгааг сурагчдад өгнө.

"Н" ОХИНД ТОХИОЛДСОН ЯВДАЛ

"Н" бол доороо 3 дүүтэй айлын том охин. Аав нь хүнд өвчний улмаас хэдэн жилийн өмнө бурхан болсноос хойш тэдний амьдрал хүндхэн болж эхэлжээ. Ээж нь нэгэн улсын эмнэлэгт сувилагч хийдэг тул ихэнхдээ ээлжинд гарч эзгүй байдаг. Заримдаа илүү цагаар ажиллаж, гэртээ ирэхгүй 2-3 хоног болох тохиолдол ч байдаг байна. Ээжийнхээ эзгүйд "Н" охин л гэрийнхээ бүх ажлыг зохицуулдаг. Дүү нараа харах, сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгөх, авах, гэрээ цэвэрлэх, хоолоо хийх, хувцсаа угаах, түлээ нүүрсээ бэлтгэх гээд "Н" охинд хийх ажил маш их байдаг.

Ээж нь хүүхдүүдээ эзгүй, харах хүнгүй орхидогтоо байнга санаа нь зовдог байсан тул хүүхдүүдэд нь ханьтай гээд хашаандаа айл буулгахаар болжээ. Хөдөөнөөс хотод орж ирээд удаагүй байгаа тохьтой, томоотой гэмээр 30 орчим насны нэг залуу, түүний дүү нь гэх 1-р курсын оюутан охин хоёрыг хашаандаа буулгажээ. Ажилдаа явсан эзгүй хойгуур нь хүүхдүүдийг нь анхаарч, орж гарч байгаарай гэж ээж нь байнга тэдэнд захидаг байв.

Гэтэл нэг өдөр "Н" охиныг гэртээ байхад хөрш залуу "Хүйтэн цай байна уу? Ахдаа аяга сайхан хүйтэн цай өгөөч. Ам цангаж үхлээ" гэсээр орж иржээ. Энэ үед дүү нар нь цэцэрлэг, сургуульдаа явсан байж. "Н" охиныг цай хийж өгөх зуур хөрш залуу түүнийг араас нь тэвэрч, хүзүү хацар гэх мэт газар нь хүчээр үнсэхийг оролдсон байна. Энэ явдал "Н" охинд маш хүнд туссан.

Дээр өгүүлсэн Н охинд тохиолдсон түүхтэй холбоотойгоор хүүхдүүдээс доорх асуултуудыг асууж, хэлэлцүүлэг өрнүүлэх ба хэлэлцүүлгийн дараа дасгал ажлын номон дээрээ товч тэмдэглэл хөтлөхийг хүснэ.

ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТУУД

Наранд юу тохиолдсон бэ?

Наран ямар арга хэмжээ авч болох вэ?

Наран өөрт тохиолдсон зүйлийн талаар хэн нэгэнд хэлэх хэрэгтэй юу?

Хэрэв тийм бол хэнд хэлэх вэ? Үгүй бол яагаад?

Хэн нэгэнд хэлэх нь ямар ач холбогдолтой бол?

Өөрт тохиолдсон зүйлийн талаар хэн нэгэнд хэлэхгүй байх нь ямар талтай бол?

Үйл ажиллагаа 3.

ГАНЦААРЧИЛСАН ДАСГАЛ АЖИЛ

Н охинд тохиолдсон түүхтэй холбоотой асуулт, хариултын дасгал ажиллуулсны дараа Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 2 буюу “Миний итгэдэг хүмүүс бол...” дасгалыг бие дааж ажиллах замаар хамгийн итгэж болох “насанд хүрсэн” хүмүүсийн жагсаалтыг гаргахыг хүснэ. “Насанд хүрсэн” гэдгийг онцгойлон сурагчдад хэлэх шаардлагатайг анхаарна уу!

ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТУУД

- Ямар нэгэн бэрхшээл тулгарахад туслалцаа үзүүлж чадах “насанд хүрсэн” хүн хэн бэ?
- Ямар нэгэн бэрхшээл, шийдэж чадахааргүй асуудал тулгарахад илэн далангүй ярилцаж болох “насанд хүрсэн” хүн хэн бэ?
- Хажууд нь байхад аз жаргал, амар тайван байдлыг мэдрүүлдэг “насанд хүрсэн” хүн хэн бэ?
- Өөрийг чинь маш сайн сонсож чаддаг “насанд хүрсэн” хүн хэн бэ?
- Өмнө нь туслалцаа үзүүлж байсан “насанд хүрсэн” хүн хэн бэ?
- Өөрийг нь маш сайн ойлгодог “насанд хүрсэн” хүн хэн бэ?

Сурагчид асуултандаа хариулж дууссаны дараа дээрх жагсаалтаас хамгийн ихээр итгэл найдвар хүлээлгэж болох, бэрхшээл тулгарахад чин сэтгэлээсээ тусалж чадах 3 хүнийг сонгох даалгавар өгнө. Хүүхдүүдээс сайн дураараа яагаад дээрх 3 хүнийг итгэж болох хүн гэж бодсон, дүгнэсэн тухай шалтгааныг нь яриулна. Ингэхдээ аль болох олон сурагчдыг хичээлд идэвхитэй оролцуулж, өөрийн бичсэн жагсаалт, сонгосон 3 хүнийхээ тухай ярих боломж олгоорой!

Үйл ажиллагаа 4.

ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

“Би хэнд итгэж болох вэ?” хэмээх энэ удаагийн хичээлийг дүгнэхийн хажуугаар багш дараах гол санаануудыг сурагчдад тайлбарлаж ойлгуулахыг эрмэлзэнэ.

- *Насанд хүрсэн хүн бүрт итгэх хэрэггүй гэдгийг “Н” охинд тохиолдсон явдлаас олж мэдсэн гэж бодож байна. ЖСХ-д өртсөн хүүхдүүдийн ярианаас үзэхэд тэдний дийлэнх нь буруу, итгэл хүлээлгэж болохооргүй “насанд хүрсэн” хүндээ итгэсэн байдаг. Иймд “насанд*

хүрсэн” хүн бүрт ямар ч шалгуургүйгээр итгэл хүлээлгэх нь буруу юм. “Яагаад би энэ хүнд итгэх ёстой вэ?” гэдэг асуултанд заавал хариулт олох хэрэгтэй.

- Мэдээж хэрэг эцэг, эх бол итгэл хүлээлгэж болох насанд хүрсэн хүмүүс мөн билээ. Тусламж, дэмжлэг хэрэгтэй болсон үед аав, ээжээсээ нууж хаалгүйгээр бүгдийг ярьж, ойлгуулж, ойлголцож хэвших нь чухал. Гэсэн хэдий ч дахиад л “Яагаад би аавдаа, ээждээ итгэдэг вэ?” гэсэн асуултанд хариулт олоорой.
- Бодит амьдрал дээр дийлэнх тохиолдолд насанд хүрсэн хүмүүс санаатайгаар болон мэдлэггүйгээсээ болоод хүчирхийлэл, тэр тусмаа жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдсэн байдаг. Танихгүй насанд хүрсэн хүнээс гадна ойр дотны хэн нэгэн, хамаатнууд ч мөн адил энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн байдаг нь харамсалтай. Иймд хамаатан учраас итгэх ёстой гэж бодох хэрэггүй шүү. Зарим хамаатан ч ЖСХ үйлдэж мэднэ.
- Цусан төрлийн биш хэрнээ ойр дотны, итгэж болох хүмүүс бидний эргэн тойронд олон байдгийг олж харахыг хичээгээрэй. Тухайлбал, сайн найз, ангийн багш, сургуулийн нийгмийн ажилтан гэх мэт хүмүүс чамд хэцүү, хүнд зүйл тохиолдоход тусалж чадна.
- Мэдээж хэрэг хүмүүс “хайртай” хүндээ хамгаас илүү ихээр итгэдэг. Яагаад гэвэл “хайртай” учраас. Гэтэл харамсалтай нь сайн таньж мэдээгүй, удаан үерхэж нөхөрлөөгүй “хайртай” гэж боддог хүмүүс ч хууран мэхэлж, ЖСХ үйлдсэн байдгийг санаарай.
- Өсвөр насны хүүхдүүдийн дийлэнх нь хамгийн сайн найзууддаа итгэж, бүх л нууцаа ярьдаг, бас тусламж эрдэг. Хэдий тийм боловч чухал шийдвэр гаргах, сонголт хийх шаардлага гарахад өсвөр насны найзуудын хамтаа гаргасан шийдвэр тийм ч зөв байж чаддаггүй. Тиймээс л “насанд хүрсэн” хүний оролцоо, дэмжлэг, зөвлөмж чухал байдаг гэдгийг санаарай!
- Өндөр хөгжсөн зарим орнуудад “Нэг хүүхдийг нэг насанд хүрсэн хүнтэй хамт байлгаж болохгүй” хэмээх дүрэм үйлчилдэг байна. Өөрөөр хэлбэл хүүхдээ хэн нэгэн таних, танихгүй насанд хүрсэн хүнтэй хамт үлдээдэггүй. Энэ нь аливаа хэлбэрийн хүчирхийллээс хүүхдээ хамгаалах нэг аргачлал юм.

Сурагчдын оролцоотойгоор өнөөдрийн хичээлийн дүгнэлтийг хийсний дараа Сурагчдад зориулсан гарын авлага дээрх **Дасгал 3**-ыг гэртээ ажиллаж ирэх даалгавар өгнө.

Хичээлийн сэдэв:

МИНИЙ БИЕИЙН ХААНА ХҮРЧ БОЛОХГҮЙ ВЭ?

Үргэлжлэх хугацаа:

40 минут

Хэрэглэгдэх зүйлс:

Флипчарт цаас

Өнгө өнгийн

фломастер

Хичээл заах аргачлал:

Тунгаан бодох

Бүлгээр ажиллах

Хэлэлцүүлэг өрнүүлэх



МОДУЛЬ 7

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙНЭНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Энэ удаагийн хичээлийн гол зорилго нь сурагчдад ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгож, хүчирхийллийн аливаа болзошгүй үйлдлийг урьдчилан таньж, өөрийгөө хамгаалах чадварт сургах явдал юм.

Хичээл нь дараах зорилтуудтай.

- Өөрийн биеийн эмзэг хэсгүүдийг мэддэг болох,
- Биеийн эмзэг, нандин хэсгүүдэд хэн хүрч, хэн хүрч болохгүй болохыг ялгаж сурах,
- Хэн нэгэн биед нь зөвшөөрөлгүй хүрсэн тохиолдолд ямар нэгэн арга хэмжээ авах чадварт суралцах,
- Хүлээн зөвшөөрөх, үл хүлээн зөвшөөрөх харилцааны талаар мэдлэгтэй болох, мэдээлэх шаардлагатай талаар ойлголт өгөх

ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Д/д	ХИЙХ ЗҮЙЛ	ХУГАЦАА	АНХААРАХ ЗҮЙЛ
1.	Хичээлийн танилцуулга	5 мин	ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон найз нөхдөө хамгаалах хамгийн анхан шатны мэдлэг бол өөрийн биеэ сайн мэддэг явдал болохыг сурагчдад ойлгуулах,
2.	Багаар ажиллах	15 мин	Бүлгийн ажил нь хүүхдүүд өөрсдийн биеийнхээ аль хэсгийг эмзэг, зөвшөөрөлгүй хүрч болохгүй газар хэмээн тодорхойлж байгаа нь чухал учраас аль болох бүх сурагчдыг тэгш оролцуулахад анхаарах,
3.	Дасгал ажил	15 мин	Тодорхой нөхцөл байдлыг хүчирхийлэлт харилцаа юу, аль эсвэл энгийн харилцаа юу гэдгийг танин мэдэх аргачлалд сургах,
4.	Тунгаан бодох / гэрийн даалгавар		Тунгаан бодох дасгал ажиллуулснаар хүүхдүүдийг өөрийн биедээ эзэн байх тухай сэдэл төрүүлэх,
5.	Хичээлийн дүгнэлт	5 мин	Дор дурьдсан дүгнэлтэнд хүрэхийн тулд бүлгийн ажил, тунгаан бодох, дасгал ажлын үеэр яригдсан зүйлсэд багш анхаарлаа хандуулах,

Үйл ажиллагаа 1.

ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Өмнөх 6 удаагийн хичээлийн хүрээнд ямар төрлийн шинэ мэдлэг, мэдээлэл хуримтлуулж, ямар чадварт суралцсан болохыг товчхон дүгнэж хэлээд энэ удаагийн сургалтын үр дүнд ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө болон найз нөхдөө хамгаалах чадварт суралцах болно гэдгийг нэмж хэлнэ. Мөн түүнчлэн хичээлийн сэдэв болон зорилго, зорилтыг товчхон танилцуулаад хичээлийн төгсгөлд сурагчид ямар шинэ ойлголт, мэдээлэл, чадвартай болсон байх талаар урьдчилсан төсөөллийг бий болгоно.

Үйл ажиллагаа 2.

БАГААР АЖИЛМАХ

Багш хүүхдүүдийг 5 хүний бүрэлдэхүүнтэй багуудад хуваана. Ингэхдээ багш өөрийн мэдэх янз бүрийн аргуудаас ашиглах боломжтой. Гагцхүү багууд хүйсийн тэгш байдлыг хангасан эсэхэд анхаарал хандуулаарай!

Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 1-ийн зааварчилгаатай танилцахыг сурагчдаас хүснэ. Улмаар баг тус бүрт флипчарт цаас болон маркер тараан өгч, “Энэ бол БИ” хэмээх дасгалыг ажиллуулж, эрэгтэй эмэгтэй хүүхдийн бүтэн биеийн дүрс зурах даалгавар өгнө.

Багууд даалгавраа гүйцэтгэсний дараа багаараа ярилцаад эрэгтэй эмэгтэй хүний биеийн хамгийн “эмзэг” гэж бодсон хэсгүүдэд “Х” тэмдэглэгээг улаан өнгөөр тавихыг хүснэ. Өөрөөр хэлбэл “хэн нэгэн зөвшөөрөлгүйгээр хүрч болохгүй биеийн хэсэг” гэсэн үг. Багийн гишүүдийн хамтын ажиллагаа, оролцоо маш чухал учир гишүүн бүрийн бодол санааг тусгах ёстойг багш сурагчдад сануулна. Даалгаврыг хийж гүйцэтгэсний дараа эрэгтэй эмэгтэй хүний биеийн “эмзэг хэсгүүд” нь хоорондоо ялгаатай байгаа эсэхийг асууж, хүүхдүүдээр өөрсдөөр нь харьцуулалт хийлгэнэ.

Дор өгөгдсөн асуултуудын хүрээнд ярилцах боломжтой бөгөөд асуултуудыг Сурагчдад зориулсан гарын авлага дээрх **Дасгал 1**-ээс олоорой.

ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТУУД

- Эмэгтэй хүний биеийн аль аль хэсгүүд хамгийн эмзэг байдаг вэ?
- Эрэгтэй хүний биеийн аль аль хэсгүүд хамгийн эмзэг байдаг вэ?
- Эрэгтэй, эмэгтэй хүний биеийн эмзэг хэсгүүдэд ялгаатай зүйл байна уу?
- Бүх хүний биеийн эмзэг хэсгүүд нь адилхан байна уу?
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийтлэг төстэй биеийн эмзэг хэсгүүд нь хаана хаана, аль хэсгүүд байна вэ?
- Содон, нийтлэг биш биеийн эмзэг хэсэг байсан уу?
Тийм бол биеийн ямар хэсэг байна вэ?

Ярилцлагын хүрээнд хүүхдүүдийн нэрлэсэн биеийн эмзэг, нандин хэсгүүдийг самбар дээр жагсаан бичнэ. Ингэснээр зарим хүүхдүүдийн хувьд “эмзэг биш” гэж боддог байсан хүний биеийн хэсгүүд нь бусад хэн нэгэнд эмзэг хэсэг нь байж болохыг таньж мэдэх боломжтой юм.

Үйл ажиллагаа 3.

ДАСГАЛ АЖИЛ

Багш сургуулийн орчинд болон сурагчдын дунд өрнөдөг харилцааг илтгэсэн доорх өгүүлбэрүүдийг ээлж дараалан уншиж танилцуулна. Энэ хэсэгт сурагчид өгүүлбэр бүр дээр өөрсдийн байр сууриа илэрхийлэх юм. Ингэхдээ тухайн өгүүлбэрт гарч буй харилцааг хүлээн зөвшөөрч байвал эрхий хуруугаа дээш нь харуулах, хүлээн зөвшөөрөхгүй бол доош нь харуулах байдлаар хөдөлгөөнөөр илэрхийлнэ. Түүнчлэн дасгал ажлын номонд өгөгдсөн Дасгал 2-т буй хүснэгтийн ард зааварчилгааны дагуу “тэмдэглэгээ” тавина.

Өгүүлбэрийн харьцаа 40:60 байх бөгөөд дийлэнх нь үл хүлээн зөвшөөрөх сөрөг харилцааг илтгэсэн байна. Багш өөрийн орон нутгийн онцлогт тохируулан өгүүлбэрүүдийг өөрчлөх, шинэчлэх бүрэн боломжтойг анхаараарай!

1. *Чамайг сургууль төгсөх шалгалтаа онц дүнтэй өгсөн гэдгийг аав чинь мэдээд чанга тэврэн хацар дээр чинь үнссэн.*
2. *С охин гудамжинд явж байгаад хагархай зам дээр хальт гишгээд хөлийн шагайгаа гэмтээжээ. Хажууд нь явж байсан залуу ирээд С охиныг суган доороос нь өргөж босгоод, бэлхүүсээр нь тэврээд гэрт нь хүргэж өгсөн.*
3. *Танай байрны нэг хөвгүүн маш хөдөлгөөнтэй /сахилгагүй/. Гадаа тоглож байхдаа байнга л байрныхаа охид, хөвгүүдийг өдөж, тоглоом шоглоом хийж явдаг. Нэг удаа байрны ах түүнийг хашраах гээд бэлэг эрхтнээс нь базсан.*
4. *Хөвгүүд охидын хөхний даруулгаас нь татаж, нурууг нь шавхуурддаг.*
5. *Хамаатны ах чинь 5 настай эмэгтэй дүүгийн чинь бөгсийг арчиж өгсөн.*
6. *Сургууль дээр зохиогдсон үдэшлэг дээр дээд ангийн аятайхан залуу чамайг бүжгэнд урьсан. Бэлхүүсний чинь доод хэсгээр тэвэрсэн.*
7. *Хичээлээ хийгээд сууж байхад багш ирээд ард зогсож, дэвтэр харангаа “сайн байна” гээд нуруу илсэн.*

Энэ нь нэг төрлийн дасгал бөгөөд сөрөг харилцааг түлхүү тусгаж өгөх нь хүүхдүүд бусдын санаатай болон санаандгүй үйлдлийг ялгаж сурах, бусдын зүгээс гаргаж байгаа ямарваа нэг харилцаа тэдэнд таагүй сэтгэгдэл төрүүлдэг болохыг ил гаргах, сурагчдын дунд олонх нь ямар харилцааг хүлээн зөвшөөрдөггүй болохыг бусадтай нь хуваалцах зорилготой юм.

Эцэст нь багш сурагчдаас хичээлийн талаарх санал бодлыг нь асуух бөгөөд юуг ойлгосон, юуг шинээр мэдэж авсныг лавлаж асууна. Мөн ЖСХ-д өртсөн хүүхдэд ямар сөрөг үр дагавар бий болох талаар чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Үйл ажиллагаа 4.**ТУНГААН БОДОХ /ГЭРИЙН ДААЛГАВАР/**

Сурагчдад зориулсан гарын авлагын Дасгал 3 буюу “Миний бие бол миний бие” хэмээх дасгалыг гэртээ ажиллах даалгавар өгнө. Дараах асуултуудтай сайтар танилцаж, тунгаан бодоод хариулж бичих юм.

АСУУЛТУУД

- Чиний биеийн эмзэг хэсгүүдэд хэн хүрч болох вэ?
- Чиний биеийн эмзэг хэсгүүдэд хэн хүрч болохгүй вэ?
- Чиний биеийн эмзэг хэсгүүдэд “санаатай” эсвэл “санамсаргүй” хүрсэн гэдгийг таньж мэдэх боломжтой юу?
- Хэрэв хэн нэгэн насанд хүрсэн хүн чиний биеийн эмзэг хэсгүүдэд хүрвэл чи яах вэ? Ямар арга хэмжээ авах вэ?
- Чи өөрийгөө хэрхэн хамгаалах вэ? Өөрийгөө хамгаалж болох аргуудыг жагсааж бичээрэй!

Үйл ажиллагаа 5.**ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ**

Хичээлээ дүгнэхдээ багш сурагчдад жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт мэдээлэл өгөх, бусдын зүгээс бие махбодид нь зөвшөөрөлгүй хүрэхэд ямар зорилготойгоор тухайн үйлдлийг хийж буйг ялгаж мэддэг болгоход чиглэгдэж байсныг дахин сануулна. Өөрөөр хэлбэл хэн нэгэн өөрт нь болон бусдад хүчирхийллийн шинжтэй үйлдэл хийж байгаа эсэхийг таних чадвартай болгох юм.

Хүчирхийллээс ангид байх хамгийн эхний алхам нь өөрийгөө хүчирхийлэлд буйгаа олж харах явдал байдаг. Иймд энэ хичээл нь ЖСХ-ээс сурагчид өөрсдийгөө болоод эрсдэлтэй бусад хэн нэгнийг (найз нөхөд, үе тэнгийнхэн, гэр бүл, хамаатан садан гэх мэт) хамгаалах чадварт суралцах мөн өөрсдөө энэ төрлийн хүчирхийллийг үйлдэгч болохоос урьдчилан сэргийлэх зорилготой юм.

Багш сурагчдад тэдний бие нь зөвхөн өөрсдийнх нь “өмч” болохыг ойлгуулж, хэдэн насандаа, хэнийг биедээ хүргэх, хүргэхгүйгээ зөвхөн тэд өөрсдөө шийдэх эрхтэй гэдгийг хэлж ойлгуулна. Хүүхдүүд өөрт нь таагүй сэтгэгдэл төрүүлж буй ямар ч харилцаа, үйлдлээс

өөрийгөө хамгаалах, түүнээс зайлсхийх бүрэн эрхтэй.

Мөн сурагчид бусдын биеийн эмзэг хэсэг хаана ч байж болохыг дээрх хичээлээс ойлгож авсан тул бусдын биед зөвшөөрөлгүй хүрч болохгүй гэдгийг энэ хэсэгт тайлбарлана. Хэрэв та хэн нэгний биеийнх аль нэг эмзэг хэсэгт нь санаатай болоод зөвшөөрөлгүй хүрвэл энэ нь жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэж буй явдал болохыг дахин ойлгуулна.

Сурагчид ЖСХ-ийн талаар ойлголттой болж, бусдын зүгээс бие махбодид нь ямар зорилготойгоор хүрч байгааг ялгаж мэдэх чадвартай болсон байна. Ингэснээр өөрийнхөө халдашгүй байдлын үүднээс зохисгүй үйлдлийн эсрэг зоригтой эсэргүүцэж чаддаг болох юм.

Зарим улс орнууд бэлгийн харилцаанд орж болох зөвшөөрөгдсөн насыг хуульчилсан байдаг төдийгүй “Зөвшилцлийн нас” хэмээх ойлголт олон нийтийн дунд түгээмэл хэвшсэн байдаг. Манай улсын хувьд Гэмт хэргийн тухай хуулийн 12.5-р зүйлд “16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орохыг хориглоон” хэмээн заасан байдаг нь нэг үгээр хэлбэл “Зөвшилцлийн нас”-ыг 16 хэмээн тогтоосон гэж ойлгогдоно. Иймд 16 насанд хүрээгүй л бол сайн дурын үндсэн дээр, өөрөө хүссэн, зөвшөөрсөн хэдий ч бэлгийн харилцаанд орох нь хууль зөрчиж буй үйлдэл болно гэдгийг сурагчдад тайлбарлаж, ойлгуулна.

12.5 дугаар зүйл. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох

1. Арван найман насанд хүрсэн хүн хохирогчийг арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийн улмаас:

2.1. хохирогчийг жирэмсэн болгосон;

2.2. бэлгийн замын халдварт өвчин халдаасан бол нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хичээлийн сэдэв:

БИ ХҮЧИРХИЙЛЭЛТ БУС
ХАРИЛЦААГ ЭРХЭМЛЭЖ
ЧАДАХ УУ?

Үргэлжлэх хугацаа:

40 минут

Хэрэглэгдэх зүйлс:

Сурагчид чөлөөтэй явж

болохуйц зай сайтай

сургалтын танхим

Тараах материал

Хичээл заах аргачлал:

Бүлгээр ажиллах

Хэлэлцүүлэг өрнүүлэх

Асуулт, хариулт



МОНДУУЛЬ 8

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХ

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

Сурагчдад жендэрт суурилсан хүчирхийлэлт бус харилцааг эрхэмлэдэг бие хүн болж төлөвших, хүчирхийллийг өөрөө үйлдэхгүй байх, эсвэл хүчирхийлэл үйлдэж буй хүнийг зогсоох гэсэн зан үйлийн өөрчлөлтийг сэдэлжүүлэх явдал юм

ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Д/д	ХИЙХ ЗҮЙЛ	ХУГАЦАА	АНХААРАХ ЗҮЙЛ
1.	Хичээлийн танилцуулга	5 мин	<i>Хүчирхийллийг хэрхэн таслан зогсоох, үүний тулд хувь хүнийхээ зүгээс ямар арга хэмжээ эрэлхийлж болох вэ гэдэг санааг сурагчдад төрүүлэх</i>
2.	Бүлгээр ажиллах	10 мин	<i>Баяраагийн түүхээр дамжуулан 3 үндсэн ойлголт өгнө. Үүнд, 1. “уйлах” гэдэг бол хүйс харгалзахгүй биологийн үйл явц (эрэгтэй, эмэгтэй хүмүүс адилхан уйлдаг) 2. бусдыг шоолох, гоочлох, нэр хоч өгөх нь сэтгэл санааны хүчирхийллийн нэг хэлбэр 3. хүчирхийлэл, дарамтыг ижил аргаар бус, хүчирхийлэлт бус харилцаа, арга замаар шийдвэрлэх боломж бий</i>
3.	Хэлэлцүүлэг	15 мин	<i>Асуудал, бэрхшээл учирсан тохиолдолд хүн бүр өөр өөр шийдэл гаргадаг ч гэлээ аливаад хүчирхийлэлт бус арга, гарах арга замыг сонгож байх нь чухал гэдгийг ойлгуулна.</i>
4.	Хичээлийн дүгнэлт	10 мин	<i>Хичээлээ дүгнэхдээ аль болох сурагчдын оролцоог хангахыг хичээх ба хүүхдүүдийн гаргаж ирээгүй санааг багш нэмж хэлнэ.</i>

Үйл ажиллагаа 1.

ХИЧЭЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Багш сурагчдад хичээлийн зорилго, зорилтыг товч танилцуулаад өмнөх хичээл дээр өөрийгөө хэрхэн хамгаалж болох тухай үзсэн бол энэ удаагийн хичээлээр бусадтай хамтран жендэрт суурилсан хүчирхийллийг зогсоохын тулд юу хийж болох тухай мэдлэгтэй болохыг сануулаад бүлгийн ажлыг эхлүүлнэ.

Үйл ажиллагаа 2.

БҮЛГЭЭР АЖИЛЛАХ

Багш хүүхдүүдэд дараах түүхийг уншиж танилцуулна.

Багагүй удаан хугацаанд үерхсэн хайртай охиноосоо харилцаагаа таслах болсон нь Б-д хүндхэн цохилт болов. Сэтгэл санаагаар унаж, болсон явдлын талаар хэн нэгэнтэй сэтгэлээ онгойтол ярилцмаар байсан учраас ангийнхаа найзад итгэж, найз охиноосоо яагаад салах болсон тухайгаа илэн далангүй ярьжээ. Найз охиноо үнэхээр их санаж байсан учраас түүнийхээ тухай ярьж байхдаа Б уйлчихав. Ангийн найз нь Б-ийн сэтгэлийг засч “эр хүн уйлдаггүй юм, охиноос болж уйлаад яахавдээ...” гэх мэтээр тайвшруулжээ.

Дараа өдөр нь Б-г ангидаа орж иртэл ангийнх нь бараг бүх хүүхдүүд “уйланхай, уйланхай” хэмээн хочилж, инээлдэж, шоолж гарчээ. Хүүхдүүд яагаад өөрийг нь ингэж хочлох болсныг ойлгож ядах юм Б-д байсангүй. Итгэл хүлээлгэж, сэтгэлээ хуваалцсан найз нь түүнийг “охиноос болж уйлсан” гэж ангийнхаа хүүхдүүдэд дэлгэсэн аж.

Б найздаа болон ангийнхаа хүүхдүүдэд маш их уурлажээ. Б яах ёстой вэ?

Дээрх түүхийг хүүхдүүдэд уншиж өгсний дараа 4 өөр хувилбар бүхий шийдлийг багш танилцуулна. Эхний хувилбарыг дэмжиж байгаа хүүхдүүд ангийн нэг буланд очиж зогсох байдлаар ангийн 4 буланд 4 баг үүсч зогсоно.

Хувилбар 1:

Б шууд л ангиас гарч явна.

Хувилбар 2:

Б-ийн уур маш их хүрсэн учраас шууд найз дээрээ очиж заамдаж авна.

Хувилбар 3:

Б уурласан хэдий ч биеэ барьж, ширээндээ сууна.

Хувилбар 4:

Б маш их уурлаж ангийнхаа хүүхдүүдэд сонсогдохуйцаар хараал хэлж, тэднийг доромжилно.

Түүх болон хувилбаруудыг Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 1-ээс харах боломжтойг хүүхдүүдэд хэлнэ.

Үйл ажиллагаа 3.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хүүхдүүдийг өөрийн сонгосон хувилбарын буланд очиж зогссоны дараа багш тэдний дунд хэлэлцүүлэг өрнүүлнэ. Яагаад тухайн хувилбарыг сонгосон болох шалтгааныг

зарим сурагчдаас тодруулсны дараа дараах асуултуудыг асуух байдлаар хэлэлцүүлгийг идэвхжүүлнэ.

Мөн түүнчлэн дээрх 4-н хувилбараас өөр шийдэл гаргах сурагч байхыг үгүйсгэхгүй тул, ийм тохиолдолд тухайн сурагчийг өөрийн суудалдаа сууж байхыг хүсээд, хэлэлцүүлгийн үеэр гаргасан шийдлийнх нь тухай, учир шалтгааных нь тухай ярилцана.

Түүнчлэн багшийн асуусан асуултад хариулж бичих даалгавар өгөх ба асуултуудыг дасгал ажлын номны Дасгал 2-оос харах боломжтойг тайлбарлана.

1. Чиний сонгосон хувилбарын дагуу Б ямар байх байсан бол?
2. Чиний сонгосон хувилбарын дагуу бусад хүмүүс /найз, ангийн хүүхдүүд/ ямар хариу үйлдэл үзүүлэх бол?
3. Чиний сонгосон хувилбарын хамгийн сайн/муу тал нь юу гэж бодож байна?
4. Чиний сонгосон хувилбарын хамгийн сайн/муу тал нь юу гэж бодож байна?
5. Чи Б-ийн оронд байсан бол яах байсан бэ? Хичээлээ хийгээд сууж байхад багш ирээд ард зогсож, дэвтэр харангаа "сайн байна" гээд нуруу илсэн.

Багш бүлгээрээ ярилцаж хамгийн зөв, хүчирхийлэлт бус шийдэл юу байж болохыг ярилцаж, хамтдаа эерэг шийдэл бүхий хувилбарыг гаргана. Хичээлийн цаг хүрэлцэхүйц байх тохиолдолд дээрх 4 хувилбараар жүжигчилсэн тоглолт хийж болно.

Үйл ажиллагаа 4.

ХИЧЭЭЛИЙН ДҮГНЭЛТ

Багш хичээлээ дүгнэхдээ доорх асуултуудыг хүүхдүүдээс асууна.

- Б хүчирхийлэлд өртсөн үү?
- Хэрэв тийм бол ямар төрлийн хүчирхийлэл байсан бэ?
- Энэ нь жендэрт суурилсан хүчирхийлэл мөн уу?
- Хэрэв тийм бол яагаад?
- Хэн хүчирхийлэл үйлдсэн бэ?

- Б-ийн найз болон ангийнх нь хүүхдүүд дээрх үйлдлийг санаатай үйлдсэн үү? Өөрөөр хэлбэл санаатайгаар Б-д сэтгэл санааны дарамт учруулсан уу?
- Ийм тохиодол амьдрал дээр гардаг уу?
- Хэрэв тийм бол ихэнхдээ хэрхэн шийдэгддэг вэ?

Багш дараах дүгнэлтийг сурагчдын хамтаар хийхийг зорино.

- Хүмүүс бие биенээ санаатай болон санамсаргүй байдлаар ялгаварлан гадуурхаж, хүчирхийлдэг. Тиймээс бусдад хандах хандлага маань ялгаварлан гадуурхсан, өөрөөр хэлбэл бусдыг гомдоосон, эсвэл заналхийлсэн, дээрэлхсэн, доромжилсон байна уу гэдэгт байнга хяналттай байх чухал. Бусдыг шоолох, гоочлох нь ч сэтгэл санааны дарамт учруулдаг гэдгийг сурагчдад ойлгуулах,
- Зөвхөн эмэгтэйчүүд уйлж, эрэгтэйчүүд уйлдаггүй гэсэн ойлголт байдаггүй. “Жендэр”-ийн хичээлтэйгээ уялдуулж, “уйлах” гэдэг бол эрэгтэй, эмэгтэй хүмүүст адил явагддаг биологийн процесс гэдгийг ухамсарлуулах,
- Хүн бүр харилцан адилгүй тул янз бүрийн нөхцөлд янз бүрийн хариу үйлдэл үзүүлдэг болохыг ойлгох хэрэгтэй. Хэдий тийм боловч хүн бүр асуудлыг хүчээр, бусдын эрхэнд халдсан байдлаар шийдвэрлэх ёстой гэсэн үг огт биш. Хүн бүр асуудлыг шийдвэрлэх хүчирхийлэлт бус аргуудыг эзэмших шаардлагатай. Өөрөөр хэлбэл хүчирхийллийг хүчирхийллээр шийдэж, таслан зогсоож болохгүй гэдэг санааг сурагчдад өгөх нь чухал.
- Сурагчдын хамт хичээлээ дүгнэсний дараа Сурагчдад зориулсан гарын авлага дээрх Дасгал 3-ыг гэртээ ажиллаж ирэх даалгавар өгөх ба өгөгдсөн асуултуудад үнэнч шударгаар хариулах хэрэгтэйг сануулна.